

МОНГОЛ ХЭЛ

2008

ХУВИЛБАР А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Өвлийн шөнө

Тас хийм хүйтэн өвлийн шөнө тэнгэрийн од оч шиг гялалзаад, уулын нурууг бүрхсэн хунгар цасны хасын өнгө түүний гэрэлд гилтгэнэнэ. Хүйтэн жавар өмнөөс үлээгээд, голын мөс тас няс хагарна. Хөндий тал мэлцийн цэлийгээд, хааяа нэг уулын орой эрвийн сэрвийн үзэгдэнэ. Шинэтгэл сар шөнө дундын үед цухуйхад гэрийн нохой түүнийг ширтэн дэмий л хуцна. Хөдөөний айлын гадуур нэг ч сонингүй. Үхэр хонь хааяа нэг хивж хэвтэнэ. Ийм нэг шөнийн гүнд холоос хэдэн морины туурай түжигнэн, хоёр манааны хүн гэрийн гадаа ирж, морийг тушин оров.


Төдөлгүй эхнэр Лхам босож, өрх татан, гал түлж, цай халаана. Харанхуй шөнийн дунд бор гэрийн тооноор утаа савсаж, улаан оч хаялах нь тэртээгээс үзэхэд үнэхээр сонирхолтой. Даруй үүрийн цолмон цэмцийн гарч ирэхэд хоёр хар хүн мордон, адууны зүг давхив. *(Д. Нацагдорж)*

- Эхийн сэдвийг олоорой.
А. Хөдөөгийн тухай
С. Хүний амьдралын тухай
Е. Шөнийн тэнгэрийн тухай
В. Цаг улирлын тухай
D. Хөдөөгийн байгалийн тухай
- Эхийн гол санааг олоорой.
А. Өвлийн шөнө хэцүү болоод уйтгартай
С. Өвлийн шөнө тунгалаг болоод соньхон
Е. Өвлийн шөнө аниргүй болоод амгалан
В. Өвлийн шөнө бүүдгэр болоод сайхан
D. Өвлийн шөнө харанхуй болоод гэрэлтэй
- Эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?
А. “Тас хийм хүйтэн ... гилтгэнэнэ” “Хүйтэн жавар ... сэрвийн үзэгдэнэ” “Шинэтгэл сар ... тушин оров” “Төдөлгүй эхнэр ... адууны зүг давхив” гэсэн 4 цогцолбор
В. “Тас хийм хүйтэн ... тушин оров” “Төдөлгүй эхнэр ... адууны зүг давхив” гэсэн 2 цогцолбор
С. “Тас хийм хүйтэн ... адууны зүг давхив” гэсэн 1 цогцолбор
D. “Тас хийм хүйтэн ... сэрвийн үзэгдэнэ” “Шинэтгэл сар ... тушин оров” “Төдөлгүй эхнэр ... адууны зүг давхив” гэсэн 3 цогцолбор
Е. “Тас хийм хүйтэн ... гилтгэнэнэ” “Хүйтэн жавар ... сэрвийн үзэгдэнэ” “Шинэтгэл сар ... хивж хэвтэнэ” “Ийм нэг шөнийн ... тушин оров” “Төдөлгүй эхнэр ... адууны зүг давхив” гэсэн 5 цогцолбор
- Эхийн хэв маягийг тодорхойл.
А. Хэрэг явдлыг цагийн дарааллаар цувуулан өгүүлсэн хүүрнэмж
В. Хэрэг явдлын учир шалтгааныг тайлбарласан тайлбарламж
С. Юмсын шинжийг зураглан тоочсон тоочимж
D. Ойлголт ухагдахууныг үгүйсгэж баталсан эргэцүүлэмж
Е. Хэрэг явдлын мөн чанарыг учирлан өгүүлсэн учирламж
- Дээрх эх найруулгын ямар төрөлд хамаарах вэ?
А. Албан бичгийн
D. Уран зохиолын
В. Сонин нийтлэлийн
E. Ярианы
C. Эрдэм шинжилгээний
- Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
“Гол сэдэвтэй, хэрэг явдал, юмс үзэгдлийн тухай төгс санааг илэрхийлсэн нийлмэл бүтцийг гэнэ.”
А. Бүтээвэр
D. Өгүүлбэр
В. Үг
E. Эх
C. Холбоо үг
- Дээрх эхийн “... тэнгэрийн од оч шиг гялалзаад ...” гэсэн хэсгийн дүрслэх ур маягийн учир юу вэ?
А. Өвлийн шөнө тунгалаг учраас одыг очтой зүйрлэсэн
В. Өвлийн шөнө уйтгартай учраас одыг очтой зүйрлэсэн
С. Өвлийн шөнө нам гүм учраас одыг очтой зүйрлэсэн
D. Өвлийн шөнө харанхуй учраас одыг очтой зүйрлэсэн
E. Өвлийн шөнө цастай учраас одыг очтой зүйрлэсэн
- Дээрх эхийн “... улаан оч хаялах нь тэртээгээс үзэхэд үнэхээр сонирхолтой” гэдэг нь хэний үнэлэмж илэрч байна вэ?
А. Зохиогчийн үнэлэмж
С. Уншигчийн үнэлэмж
E. Хоёр манааны хүний үнэлэмж
В. Эхнэр Лхамын үнэлэмж
D. Хоёр хар хүний үнэлэмж

9. Дараах нийлмэл өгүүлбэрийн онцлон тодруулсан хэсэг нь ямар өгүүлбэр вэ?
Шинэтгэл сар шөнө дундын үед цухуйхад гэрийн нохой түүнийг ширтэн дэмий л хуцна.
 А. Байдал заасан байц гишүүн өгүүлбэр В. Цагийн байц гишүүн өгүүлбэр
 С. Орны байц гишүүн өгүүлбэр Д. Дүрийн байц гишүүн өгүүлбэр
 Е. Зорилго заасан байц гишүүн өгүүлбэр
10. Дээрх (9-р) өгүүлбэрийн гурван бүрэлдэхүүнт цөм бүтцийг зөв тодорхойлсныг ол.
 А. Сар шөнө цухуйх В. Нохой түүнийг ширтэх С. Нохой ширтэн хуцах
 D. Шинэтгэл сар цухуйх Е. Гэрийн нохой хуцах
11. Эхэд байгаа “Ийм нэг” гэсэн төлөөлөх утгат холбоос юуг төлөөлсөн бэ?
 А. Гэрийн нохойг төлөөлсөн В. Шинэтгэл сарыг төлөөлсөн
 С. Өвлийн шөнийг төлөөлсөн Д. Тэнгэрийн одыг төлөөлсөн
 Е. Манааны хүнийг төлөөлсөн
12. Дараах холбоо үгсээс аль нь утгазүйжсэн холбоо үг вэ?
 А. Өвлийн шөнө В. Тэнгэрийн од С. Голын мөс
 D. Түүний гэрэл Е. Хасын өнгө
13. Дараах өгүүлбэрийн “үлээгээд” гэсэн үгийг утгаар нь солин найруулбал аль үг хамгийн оновчтой байж болох вэ?
Хүйтэн жавар өмнөөс үлээгээд, голын мөс тас няс хагарна.
 А. Илбээд В. Сэвэлзээд С. Сийгээд
 D. Тачигнаад Е. Хөвөлзөөд
14. “Гэрийн нохой түүнийг ширтэн дэмий л хуцна” гэсэн өгүүлбэрийн “гэрийн” гэдэг нь өгүүлбэрт ямар гишүүн болсон бэ?
 А. Захын дэлгэрүүлэгч гишүүн, орны байц
 В. Дэд дэлгэрүүлэгч гишүүн, хамжсан тодотгол
 С. Гол дэлгэрүүлэгч гишүүн, шууд бус тусагдахуун
 D. Дэд дэлгэрүүлэгч гишүүн, үйлийн тодотгол
 Е. Гол дэлгэрүүлэгч гишүүн, харьяалахын тодотгол
15. Дараах өгүүлбэрийг тонгоргон хувиргасан хувиргал аль нь вэ?
Тас хийм хүйтэн өвлийн шөнө тэнгэрийн од оч шиг гялалзаад, уулын нурууг бүрхсэн хунгар цасны хасын өнгө түүний гэрэлд гилтгэнэнэ.
 А. Тас няс хийм жавартай нэн хүйтэн өвлийн энэ шөнө дээд тэнгэрийн од оч дөл шиг гялалзаад, өндөр уулын нурууг нэлд нь бүрхсэн их хунгар цасны хасын өнгө түүний гэрэлд гилтгэнэнэ.
 В. Тэнгэрийн од гялалзаад, цасны өнгө гилтгэнэнэ.
 С. Тас хийм хүйтэн өвлийн шөнө тэнгэрийн од оч шиг гялалзаад, уулын нурууг бүрхсэн хунгар цасны хасын өнгө түүний гэрэлд гилтгэнэнэ. Цас цайвалзаж, салхи үлээгээд хүйтэн үнэхээр зориг мохоомоор.
 D. Уулын нурууг бүрхсэн хунгар цасны хасын өнгө гэрэлд нь гилтгэнэнэ, оч шиг гялалзсан одот тэнгэртэй өвлийн шөнийн тас хийм хүйтэн.
 Е. Өвлийн шөнө өндөр газрын хүйтэн чөмөр царцмаар ч, оддын гэрэлд цайран гялтганах их цасан үнэхээр гоёмсог.
16. Үгийн бүтцээр зөв задалсныг олоорой.
 А. Цэ-лий-Ø-ээд В. Цэлий-Ø-ээд С. Цэл-ий-Ø-Ø-ээд
 D. Цэл-ий-Ø-ээд Е. Цэл-ий-ээд
17. Дараах өгүүлбэрээс үйл явдлыг зэрэгцүүлэн холбох үүрэгтэй бүтээврийг олоорой.
Хүйтэн жавар өмнөөс үлээгээд, голын мөс тас няс хагарна.
 А. -өөс В. -ээд С. -ын D. -р Е. -на
18. Төсөөт үг орсон хэсгийг олоорой.
 А. Эрвийн сэрвийх В. Ширтэн хуцах С. Үхэр хонь
 D. Өрх татах Е. Хар хүн
19. Дараах өгүүлбэрт жинхэнэ нэрийн тийн ялгалын нөхцөлтэй үг хэд байна?
Ийм нэг шөнийн гүнд холоос хэдэн морины туурай түжигнэн, хоёр манааны хүн гэрийн гадаа ирж, морийг тушин оров.
 А. 5 В. 6 С. 7 D. 8 Е. 9
20. Дараах холбоо үгсийн бүгдэд нь тохирох шинжийг олоорой.
 “Хунгар цас, хүйтэн жавар, хөндий тал, шинэтгэл сар, бор гэр, улаан оч”
 А. Хамжиж угсарсан нэрийн холбоо үг В. Найрч угсарсан нэрийн холбоо үг
 С. Дагуул үг нь бүгд өнгө заасан тэмдэг нэр D. Цөм үг нь бүгд орон заасан үг
 Е. Бүгд зэрэгцэн холбогдсон

21. “Шөнө” гэдэг үгийн эсрэг утгат үг аль нь вэ?
А. Өглөө В. Орой С. Өдөр D. Үдэш E. Шөнө дөл
22. Тооны нэр шилжсэн утгаар орсон өгүүлбэрийг олж тэмдэглээрэй.
А. Хөдөөний айлын гадуур нэг ч сонингүй
В. Үхэр хонь хааяа нэг хивж хэвтэнэ
С. Ийм нэг шөнийн гүнд холоос хэдэн морины туурай түжигнэн ...
D. Хоёр манааны хүн гэрийн гадаа ирж ...
E. Хоёр хар хүн мордон адууны зүг давхив
23. Дараах бүлэг үгсээс аль нь төрөл биш үг вэ?
“Үзлэг, үзэм, үзэмж, үзвэр, үзэл, үзмэр, үзэсгэлэн, үзэг, үзүүлэн”
А. Үзлэг, үзэмж В. Үзвэр, үзэл C. Үзэмж, үзмэр
D. Үзэм, үзэг E. Үзүүлэн, үзэсгэлэн
24. Дараах бүлэг үгсийн тухай ойлголтуудаас зөвийг олоорой.
“Шоудах, гуялах, чадхийх, сэгсрэх, савах, зад авах, программдах”
А. Утга зохиолын хэл хөгжиж, хэлэлцэгч хүмүүсийн боловсрол дээшлэх тусам эдгээр этгээд үгсийн хэрэглээ ихэсдэг
В. Утга зохиолын хэл хөгжиж, хэлэлцэгч хүмүүсийн боловсрол дээшлэх тусам эдгээр этгээд үгсийн хэрэглээ багасдаг
С. Утга зохиолын хэл хөгжиж, хэлэлцэгч хүмүүсийн боловсрол дээшлэх тусам эдгээр этгээд үгсийн хэрэглээ хэвийн болдог
D. Утга зохиолын хэл хөгжиж, хэлэлцэгч хүмүүсийн боловсрол дээшлэх тусам эдгээр этгээд үгсийн хэрэглээ нэмэгддэг
E. Утга зохиолын хэл хөгжиж, хэлэлцэгч хүмүүсийн боловсрол дээшлэх тусам эдгээр этгээд үгсийн хэрэглээ өөрчлөгддөггүй
25. “Хэвтэнэ” хэмээх үгийн язгуурыг зөв тодорхойлсныг олоорой.
А. Идэвхгүй дуурайх язгуур В. Идэвхтэй нэр язгуур C. Идэвхгүй дүрслэх язгуур
D. Идэвхтэй үйл язгуур E. Идэвхтэй тэмдэг нэр язгуур
26. Үгийн аймгаар зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
А. Тогло, барь, унт, сана, адуу
В. Ажилчин, хүмүүж, эрдэмтэн, хүүхэлдэй, бичээч, ширээ
С. Дээр, дотор, цаана, дэргэд, урдуур, гадагш
D. Баян, хатуу, аймхай, хурга, цооронхой, шударга
E. Дөрвөлжин, дээшээ, дээвэр, дэлхий, давхи
27. “Алдах” хэмээх үгийн салаа утгат үгсээс доорх тайлбарт тохирох хэсгийг олоорой.
Үгийн тайлбар нь: Үр ашиггүй ажил оролдох, дэмий цаг өнгөрүүлэх
А. Морио алдах В. Хэмжээ алдах C. Барьц алдах
D. Ёс алдах E. Ажлаа алдах
28. “Хасын цагаан” хэмээх холбоо үгийн утга, бүтцийг ажиглаад адил утга, бүтэцтэй үгийг олоорой.
А. Толгодын орой В. Тэнгисийн мандал C. Хуурын чавхдас
D. Тэнгэрийн цэнхэр E. Галын дэргэд
29. Монгол хэлний цагаан толгой хэдэн эгшиг үсэгтэй вэ?
А. 4 В. 7 C. 13 D. 9 E. 10
30. 4 үсэг, 3 авианаас бүтсэн үгийг олоорой.
А. Найр В. Уран C. Үзэм D. Үнэг E. Утга
31. Дараах өгүүлбэрийн таслалыг хасвал өгүүлбэрт утга санааны өөрчлөлт гарах уу? Зөв хариултыг олоорой.
“Төмөр, хүрз авав”
А. Утга санаа нь огт өөрчлөгдөхгүй
В. Гишүүдийн байр хувирахгүй учраас төдий л өөрчлөгдөхгүй
С. Зөвхөн өгүүлэхүүний утга өөрчлөгдөнө
D. Өгүүлбэрийн бүх гишүүд нь хэвээр байгаа учраас өөрчлөгдөхгүй
E. Утга санаа нь огт өөр болно
32. Өнгөрсөн цагийн “-жээ” нөхцөл залгахад аль үг нь бусдаасаа өөр бичигдэх вэ?
А. Захь В. Харь C. Соль D. Тавь E. Ань
33. Бүгдийг зөв бичсэн хэсгийг олоорой.
А. Бодлыг, өвөлийг, гэрлийг В. Атрыг, болрыг, өдрийг
С. Дэвтрийг, төлчинийг, жинчинийг D. Малчидыг, оёдолчидыг, төлчидийг
E. ястаныг, төрөлхтнийг, үсчинийг

34. Дараах өгүүлбэрийг крилл бичигт зөв хөрвүүлснийг олоорой.



- A. Аугаа хүчийн ихэтгэе гэвэл цэргээ асар
Уудам сул жаргая гэвэл эеэ хичээ
- B. Аугаа хүчээ өгүүтгэе гэвэл цэргээ асар
Уудам сул жаргая гэвэл эеэ хичээ
- C. Аугаа хүчээ ихэтгэе гэвэл цэргийн асар
Уудам сул жаргая гэвэл эеэ хичээ
- D. Аугаа хүчээ ихэтгэе гэвэл цэргээ асар
Уудам сул жаргая гэвэл эеэ хичээ
- E. Аугаа хүчээ ихэтгэе гэвэл цэргээ асар
Уудам сул жиргэе гэвэл эеэ хичээ

35. Жинхэнэ нэр бүтээх “**ᠬᠢ**” дагавар авах үг аль нь вэ?

- A. Нис B. Үз C. Уна D. Шүт E. Эмнэ

36. Нэрийн тийн ялгалын нөхцөлөөр буруу хувилгасныг олоорой.

- A. **ᠬᠢᠨᠠᠨ** **ᠮᠠ** B. **ᠬᠢᠨᠠᠨ** **ᠮᠤ** C. **ᠬᠢᠨᠠᠨ** **ᠨ** D. **ᠬᠢᠨᠠᠨ** **ᠮᠠᠨ** E. **ᠬᠢᠨᠠᠨ** **ᠮᠠᠨ**

37. Монгол бичгээр “**ᠮᠤ**” төгсгөлтэй бичдэг үгийг олоорой.

- A. Ус B. Улс C. Баяс D. Бос E. Сонс

38. “Монголын Нууц Товчоон” зохиолд:

Одтой тэнгэр орчиж, олон улс байлдаж

Орондоо унтах завгүй, олзлон булаалдаж байв ... хэмээн шүлэглэсэн нь хэдий үеийн монголчуудын нийгмийн байдлыг дүрсэлсэн бэ?

- A. Хүннүгийн үе B. Сянбигийн үе C. XIII зууны үе
- D. XV-XVI зууны үе E. XX зууны үе

39. Доорх зохиолуудын дарааллыг ажиглаад зөв зүй тогтлыг олоорой.

- A. “Монголын Нууц Товчоон”, Б. Явуухулан “Би хаана төрөө вэ?”, “Убаши Хун тайжийн тууж”, Д. Равжаа “Ичиг, ичиг”
- B. “Монголын Нууц Товчоон”, Б. Явуухулан “Би хаана төрөө вэ?”, Д. Равжаа “Үлэмжийн чанар”, Ч. Лодойдамба “Тунгалаг тамир”
- C. Б. Явуухулан “Би хаана төрөө вэ?”, Д. Равжаа “Үлэмжийн чанар”, Д. Нацагдорж “Хөдөө талын үзэсгэлэн”, Д. Намдаг “Цаг төрийн үймээн”
- D. Б. Ринчен “Үүрийн туяа”, Ч. Лодойдамба “Тунгалаг тамир”, Д. Намдаг “Цаг төрийн үймээн”, С. Удвал “Их хувь заяа”
- E. Б. Явуухулан “Мөнгөн хазаарын чимээ”, Д. Нацагдорж “Миний нутаг”, Б.Лхагвасүрэн “Боржигоны бор тал”, В. Инжаннаши “Хөх судар”

40. Д.Нацагдоржийн зохиол бүтээлийн дүрслэлийн гол онцлог юу вэ?

- A. Утга санаа далд, уянгалаг дүрслэл B. Утга санаа далд, хүүрнэсэн дүрслэл
- C. Утга санаа яруу, уран хурц дүрслэл D. Утга санаа тодорхой, хүүрнэсэн дүрслэл
- E. Харилцаанд түшиглэсэн уран хурц дүрслэл

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Өгүүлбэрийн цэгийн оронд утга тохирох үгсийг зөв харгалзуулан олж, хүлэг морины тухай нэгэн цогцолборыг бүтээгээрэй. (5 оноо)

- | | |
|---------------------------------|---------------|
| A. Өлөн чоно ... | 1. Цохиулшгүй |
| B. Өшөөтөн дайсан ... | 2. Гүйцэшгүй |
| C. Муу эзэнд ... | 3. Хүршгүй |
| D. Мухар ташуураар ... | 4. Барьшгүй |
| E. Хангайн салхинаас өөр юм ... | 5. Учиршгүй |

2.2. Хэлц өгүүлбэрийг гол санаатай нь зөв харгалзуулаарай. (5 оноо)

- | | |
|--|-------------------------|
| A. Ухнанд явсан хүү, ямаа ишиглэсэн хойно ирэх | 1. Зүрхэнд орох |
| B. Ямааны мах халуун дээрээ | 2. Цагаа олоогүй |
| C. Айсан нохой арав хоног хуцах | 3. Цаг тухайд нь |
| D. Ишиг эврээ ургахаар, эхийгээ мөргөх | 4. Юм бүхэн шалтгаантай |
| E. Овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ | 5. Тусыг усаар |

2.3. Дараах зэргэд өгүүлбэрүүдийг бүтээхэд тодруулсан үгс ямар утга, үүрэгтэй орсныг зөв тодорхойлж харгалзуулаарай. (5 оноо)

- | | |
|---|---|
| A. Тоонотой гэрт толгой холбож
Тостой тогоонд хошуу холбох | 1. Шинжийн утгат гишүүд зэрэгцсэн |
| B. Арвин малтай айргийн эзэн болтугай
Буман малтай бутангийн эзэн болтугай | 2. Үйлийн утгат гишүүд зэрэгцсэн |
| C. Үг ил нь сайн
Үнэг улаан нь сайн | 3. Орны утгат гишүүд зэрэгцсэн |
| D. Оролдвол нэгийг бүтээнэ
Уралдвал нэг нь түрүүлнэ | 4. Тоо хэмжээний утгат гишүүд зэрэгцсэн |
| E. Муу хүн сонжооч
Мухар үхэр сэжээч | 5. Юмын утгат гишүүд зэрэгцсэн |

2.4. “Хув Нагваралын тууж” зохиол дахь захидлын далд утгыг тайлсан тайлбартай нь зөв харгалзуулаарай.

(5 оноо)

- | | |
|-----------------------------|-------------------------|
| A. ...Цавьдар морь чинэгтэй | 1. Өөрөө уна гэсэн үг |
| B. Бор морь чимэгтэй | 2. Өдөр бүү яв гэсэн үг |
| C. Өдөр балар | 3. Бүү унт гэсэн үг |
| D. Шөнө тодорхой | 4. Шөнө яв гэсэн үг |
| E. Их хар, бага цавч ... | 5. Эхдээ унуул гэсэн үг |

ХУВИЛБАР С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Шувуун саарал

Хөндий талын зэрэглээ мяралзан жирэлзэх нь холоос үзэхэд сонин. Хэдэн жижигхэн юм түүний дунд сүүмэлзэх нь яахин даруй танигдана.

Уудам газар дураар сэлгүүцэх хээр хөдөөгийн цэнгэл, хурдан морины ирэлзэн ирэх эр хүний бахдал, ойртон үзвэл хэдэн залуу морь тарлаж байна.

Сүрэнхүү саарал морины амыг арайхан тогтоож, овооны дэргэд буун, хөлсийг нь хусаад, тамхи татан байх бөгөөд ташаа нь тэвхийж, хавирганы яс нь зураисан ялгуун саарал морь нь тогтож ядан, гоо сайхан дөрвөн хөлөөрөө ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сэжих нь агаарт дэгдэж, үүлэнд умбан алдмаар, хоёр чихээ солбилзуулан, хааяа нэг шилгээж, эзнийхээ сэтгэлийг баясгана.

Энэ үед удаа дараа хүрч ирсэн хүмүүс түүнийг гайхан магтах бөгөөд шувуун саарал гэж нэрийдэн, Сүрэнхүүгээс шалж, өдий төдий залуу тарган морины үнэ хаялцана.

Сүрэнхүү морины толгойг илбэж худалдахгүй гэнэ. Цугаар нэг зэрэг шувуун саарлын тухай яриа бололцоод, оройн шар наранд зүг зүг, гэр гэртээ хоёр гурваараа нийлэлдэн, ярилцан, исгэрэлдэн одоцгооно.

(Д. Нацагдорж)

- Эхийн сэдвийг олоорой.







A. Малчин хүний тухай	B. Морины наймааны тухай
C. Эр хүн, эрдэнэт хүлгийн тухай	D. Зэрэглээт талын тухай
E. Цэнхэр хөндийн тухай	
- Эхийн гол санааг олоорой.

A. Дэлгэр цагийн тааламжтай байдал	B. Эр хүний чимэг эмээлт хурдан хүлэг
C. Адуучин залуусын жавхаатай байдал	D. Хөдөөний хүмүүсийн жаргалтай амьдрал
E. Хөдөө нутгийн сайхан байгалийн өнгө төрх	
- Эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?

A. “Хөндий талын зэрэглээ ... яахин даруй танигдана”, “Уудам газар ... морь тарлаж байна”, “Сүрэнхүү ... эзнийхээ сэтгэлийг баясгана”, “Энэ үед ... исгэрэлдэн одоцгооно” гэсэн 4 цогцолбор
B. “Хөндий талын зэрэглээ ... морь тарлаж байна”, “Сүрэнхүү саарал морины ... эзнийхээ сэтгэлийг баясгана”, “Энэ үед ... исгэрэлдэн одоцгооно” гэсэн 3 цогцолбор
C. “Хөндий талын зэрэглээ ... эзнийхээ сэтгэлийг баясгана”, “Энэ үед ... исгэрэлдэн одоцгооно” гэсэн 2 цогцолбор
D. “Хөндий талын зэрэглээ ... яахин даруй танигдана”, “Уудам газар ... эзнийхээ сэтгэлийг баясгана”, “Энэ үед ... исгэрэлдэн одоцгооно” гэсэн 3 цогцолбор
E. “Хөндий талын зэрэглээ ... морь тарлаж байна”, “Сүрэнхүү саарал морины ... исгэрэлдэн одоцгооно” гэсэн 2 цогцолбор

4. Дээрх эхэд “шувуун саарал”-ыг “... агаарт дэгдэж, үүлэнд умбан алдмаар...” хэмээн дүрсэлсний учир юу вэ?
 А. Салхинаас хурдан хүлгийг дүрсэлсэн
 В. Ижилгүй сайхан, эрэмгий хүлгийг дүрсэлсэн
 С. Давхиж байгаа хүлгийг дүрсэлсэн
 D. Уяа сойлго нь ханасан морийг дүрсэлсэн
 E. Өнгө зүснийх нь сайхныг дүрсэлсэн
5. Эхийн хэв маягийг тодорхойл.
 А. Үйл явдлыг цагийн дарааллаар өгүүлсэн хүүрнэмж
 В. Үйл явдлыг зураглан тоочсон тоочимж
 С. Хэрэг явдлын мөн чанарыг тайлбарласан тайбарламж
 D. Юмсын шинж, үр дагаврыг учирлан илэрхийлсэн учирламж
 E. Хэрэг явдлыг эргэцүүлэн бясалгаж дүрсэлсэн эргэцүүлэмж
6. Дээрх эх найруулгын ямар төрөлд хамаарах вэ?
 А. Албан бичгийн
 В. Ярианы
 С. Уран зохиолын
 D. Сонин нийтлэлийн
 E. Эрдэм шинжилгээний
7. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
 “Эхийг бүрдүүлэгч хамгийн их нэгжийг гэнэ”
 А. Мөчлөг
 В. Холбоо үг
 С. Өгүүлбэр
 D. Нийлмэл өгүүлбэр
 E. Цогцолбор
8. Дээрх эхийн “Хөндий талын зэрэглээ мяралзан жирэлзэх нь холоос үзэхэд сонин” гэдэгт хэний үнэлэмж илэрч байна вэ?
 А. Сүрэнхүүгийн үнэлэмж илэрсэн
 В. Сүрэнхүү, уншигч хоёрын үнэлэмж давхар илэрсэн
 С. Уншигчийн үнэлэмж илэрсэн
 D. Морь тарлагч залуусын үнэлэмж илэрсэн
 E. Зохиогчийн үнэлэмж илэрсэн
9. Дараах өгүүлбэрийн төгс өгүүлэхүүн аль нь вэ?
 Хэдэн жижигхэн юм түүний дунд сүүмэлзэх нь яахин даруй танигдана.
 А. Юм
 В. Сүүмэлзэх нь
 С. Яахин даруй
 D. Түүний дунд
 E. Танигдана
10. Үгийн бүтцээр зөв задалсныг олоорой.
 А. Жир - лз - Ø - х
 В. Жирэлз - Ø - Ø - х
 С. Жи - рэлз - Ø - Ø - х
 D. Жир - лз - Ø - Ø - х
 E. Жирэл - з - Ø - х
11. Дээрх эхийн “энэ үед” гэсэн холбоос юуг төлөөлсөн бэ?
 А. Орон байрыг
 В. Үйлийн эзнийг
 С. Юмын шинжийг
 D. Цаг хугацааг
 E. Хэр хэмжээг
12. Дараах холбоо үгсээс аль нь утгазүйжсэн холбоо үг вэ?
 А. Үнэ хаялц
 В. Ойртон үз
 С. Дураар сэлгүүц
 D. Дэргэд буу
 E. Хүрч ир
13. Дараах өгүүлбэрийн “сэлгүүцэх” гэсэн үгийг утгаар нь солин найруулбал аль үг хамгийн оновчтой тохирох вэ?
Уудам газар дураар сэлгүүцэх хээр хөдөөгийн цэнгэл...
 А. Цэнгэх
 В. Жаргах
 С. Тэнэх
 D. Зугаалах
 E. Гүйх
14. Дараах өгүүлбэрийг дэлгэрүүлэн хувиргасныг олоорой.
Хөндий талын зэрэглээ мяралзан жирэлзэх нь холоос үзэхэд сонин
 А. Өндөр уулын хярд өнгийн будан татах нь алсаас харахад гайхмаар
 В. Холоос сонин үзэгдэх нь хөндий талын мяралзан жирэлзсэн зэрэглээ
 С. Саруулхан хөндий талын уяхан цагаан зэрэглээ нүдний үзүүрт мяралзан жирэлзэх нь зайдуу холоос үзэхэд сонин
 D. Зэрэглээ үзэхэд сонин
 E. Уудам талын наран ургаж мандах нь дэргэдээс харахад гайхалтай
15. Дараах өгүүлбэрийн онцлон тодруулсан хэсгийн бүтцийг тодорхойл.
Хөндий талын зэрэглээ мяралзан жирэлзэх нь холоос үзэхэд сонин.
 А. Тусагдахуун гишүүн өгүүлбэр
 В. Тодотгол гишүүн өгүүлбэр
 С. Байц гишүүн өгүүлбэр
 D. Өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэр
 E. Өгүүлэхүүн гишүүн өгүүлбэр
16. Дээрх (15-р) өгүүлбэрийн гурван бүрэлдэхүүнт цөм бүтцийг зөв тодорхойлсныг ол.
 А. Зэрэглээ мяралз
 В. Зэрэглээ жирэлз
 С. Зэрэглээ үз
 D. Зэрэглээ сонин
 E. Зэрэглээ хол

17. Эхээс түүвэрлэсэн үгсийн зүйлчлэлийг ажиглаад утгын хамааралгүй үгийг олоорой.
Эр хүн, залуус, агаар, Сүрэнхүү, эзэн, хүмүүс
А. Залуус В. Агаар С. Эзэн D. Сүрэнхүү E. Хүмүүс
18. Дараах өгүүлбэрийн үйл явдлыг цагийн дарааллаар холбох үүрэгтэй бүтээврийг зөв бүлэглэснийг олоорой.
Сүрэнхүү саарал морины амыг арайхан тогтоож, овооны дэргэд буун, хөлсий нь хусаад, тамхи татан байх бөгөөд...
А. -ны, -ыг, -н В. -ж, -н, -аад С. -ны, -ж, -аад
D. -нь, -аад, -н E. -ны, -н, -өөд
19. Дээрх эхэд байгаа дүрслэлүүдээс хүлэг морины галбир төрхийг дүрсэлсэн хэсгийг ол.
А. Хурдан морины ирэлзэн ирэх эр хүний бахдал
В. Ялгуун саарал морь
С. Уран сайхан толгойгоо ийш тийш сэжнэ
D. Ташаа нь тэвхийж хавирганы яс нь зурагсан
E. Хоёр чихээ солбилзуулна
20. Дараах өгүүлбэрт жинхэнэ нэрийн тийн ялгалын нөхцөлтэй үг хэд байна вэ?
Ташаа нь тэвхийж хавирганы яс нь зурагсан ялгуун саарал морь нь тогтож ядан, гоо сайхан дөрвөн хөлөөрөө ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сэжнэ.
А. 5 В. 6 С. 7 D. 8 E. 9
21. Үндсэн утгаараа дараах тайлбарт тохирох үг аль нь вэ? Тайлбар нь:
Эвэртэй амьтны бусдыг өрөөсөн эврийн үзүүрээр олих, толгойгоо займрах
А. Цавчлах В. Дэгдэх С. Солбилзуулах
D. Зурагх E. Сэжих
22. Дээрх эхээс авсан холбоо үгсийг ажиглаад адил бүтэц үүрэгтэй үгийг олоорой.
Зэрэглээ мяралз, юм сүүмэлз, Сүрэнхүү буу, морь шилгээ, хүмүүс магт
А. Ташаа нь тэвхий В. Агаарт дэгд С. Тамхи тат
D. Хөлсий нь хус E. Тогтож яд
23. Бүгд үйлийн хам холбох “-н” нөхцөлтэй үг орсон хэсгийг олоорой.
А. Мяралзан, сонин, хэдэн В. Ойртон, арайхан, буун
С. Жижигхэн, шувуун, ирэлзэн D. Татан, ядан, ээлжлэн
E. Дөрвөн, гайхан, тарган
24. “баяс” хэмээх үгийн төрөл утгат үг аль нь вэ?
А. Баялаг В. Баян С. Баяр
D. Баяж E. Бай
25. Дараах өгүүлбэрт “алах” гэсэн үгийг “төхөөрөх” хэмээн нэрлэсэн нь зөв үү? Зөв хариултыг ол.
“Самбуу гуайнх өнөөдөр хонь төхөөрөх гэнэ”
А. Зэхэх, бэлтгэх гэсэн огт өөр утгыг илэрхийлсэн учир буруу
В. Хагуу үг хэллэгийг ийнхүү эерүүлэн хэрэглэх ёс бий
С. Өгүүлбэрийн утга алдагдсан байна
D. Хонио бэлчээх гэсэн өөр санааг илэрхийлжээ
E. Төрөлх хэлний цэвэр байдлыг эвддэг этгээд үгийн нэг хэлбэр
26. Үгийн аймгаар зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
А. Зэрэглээ, газар, бахдал, уран, яс, эзэн
В. Магтах, гайхах, хүрэх, баясгах, халх
С. Дээр, дотор, цаана, дүүрэн, урдуур, гадагш
D. Жирэлзэх, үзэх, сэлгүүцэх, тарлах, цавчлах, дэгдэх
E. Уудам, овоо, дэргэд, татах, сайхан, дараа
27. “Буух” гэдэг үгийн салаа утгат үгсээс доорх тайлбарт тохирох хэсгийг олоорой.
Үгийн тайлбар нь: албаны хугацаа дуусган ажиллахыг болих
А. Мориноос буух В. Цалин буух С. Манаанаас буух
D. Сүүдэр буух E. Шатаар буух
28. Дээрх эхэд байгаа “ялгуун саарал морь” хэмээх холбоо үгтэй утга, бүтцээрээ адил үгийг олоорой.
А. Хүрэн халзан үнээ В. Алаг доохор алчуур С. Цагаан шар хүн
D. Зөөлөн цэнхэр өнгө E. Миний хэнз хурга
29. Крилл монгол бичгийн цагаан толгой хэдэн туслах эгшигтэй вэ?
А. 2 В. 4 С. 6 D. 7 E. 13
30. 6 үсэг, 5 авианаас бүтсэн үгийг олоорой.
А. Хаалга В. Самбар С. Нарлаг
D. Аагтай E. Харсан

31. Дараах харилцан ярианд цуваа цэг хэрэглэсэн нь зөв үү? Зөв хариултыг олоорой.
 “- Миний морь гэнээ. Би чинь мод унасан... гэтэл охин инээмсэглээд,
 - Ээж танд морь явуулсан юм гэв”
 А. Өгүүлбэрийн санаа алдагдсан байна
 В. Ойлгомжгүй болсон байна
 С. Уран зохиолын дүрийн сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн байна
 D. Зөвхөн өгүүлбэрийн төгсгөлд л хэрэглэх ёстой
 E. Үүний оронд таслал байх ёстой
32. “-цгаа” нөхцөл залгахад аль үг нь бусдаасаа өвөрмөц бичигдэх вэ?
 А. Яв В. Унш С. Хар D. Тар E. Ав
33. Бүгдийг зөв бичсэн хэсгийг олоорой.
 А. Барья, харая, бодъё В. Өгөө, үзье, бичье С. Уншъя, хэлье, идье
 D. Зурая, хадая, нэмэе E. Явъя, тосъё, босоё
34. Дараах өгүүлбэрийг крилл бичигт зөв хөрвүүлснийг олоорой.
 А. Идэр явсан явдлыг шөнө шүүгтүн
 Ичгүүр гэмт явдлыг ятгаж орхигтун
 В. Өдөр явсан явдлыг шинэ шүүгтүн
 Ичгүүр гэмт явдлыг ятгаж орхигтун
 С. Идэр явсан явдлыг шөнө шүүгтүн
 Ичгүүр хэмт явдлыг ятгаж орхигтун
 D. Өдөр явсан явдлыг шөнө шүүгтүн
 Ичгүүр хэмт явдлыг ялгаж орхигтун
 E. Өдөр явсан явдлыг шөнө шүүгтүн
 Ичгүүр гэмт явдлыг ятгаж орхигтун
35. Монгол бичигт олон тооны “” дагавар авах үгийг олоорой.
 А. Бичиг В. Зун С. Цэцэг D. Ном E. Уул
36. Нэрийн тийн ялгалын нөхцөлөөр буруу хувилгасныг олоорой.
 А.  В.  С.  D.  E. 
37. Монгол бичгээр урт эгшгийг богино эгшгээр тэмдэглэдэг үгийг олоорой.
 А. Хаалга В. Үнээ С. Ноос D. Ээж E. Инээх
38. “Монголын Нууц Товчоон” зохиолд нэгэн хүний эрэмгий дайнч чанарыг:
 “... Шөвөг хатгах зайгүй, шөрөг төмөр өмсч
 Зүү шивэх завсаргүй, зүймэл хуяг өмсч...” дайнд ордог хэмээн уран яруу шүлэглэсэн байдаг. Энэ дүр хэн бэ?
 А. Хасар В. Чингис С. Отчигин D. Бэлгүтэй E. Бэгтэр
39. Доорх зохиолуудын төрөл зүйлийг ажиглаад, зөв зүй тогтлыг олоорой.
 А. “Гурван зуун тайчуудыг дарсан домог”, “Оюун түлхүүр”, “Тоть шувууны сургаал”,
 Д.Равжаа “Цаасан шувууны үлгэр”
 В. “Эр хоёр загалын тууж”, “Оюун түлхүүр”, “Тоть шувууны сургаал”, Д.Равжаа “Цаасан
 шувууны үлгэр”
 С. “Эр хоёр загалын тууж”, “Оюун түлхүүр”, “Тоть шувууны сургаал”, Хуульч Сандаг
 “Сайн муу бичээч нарын хэлсэн үг”
 D. “Эр хоёр загалын тууж”, “Өнчин хүүгийн цэцэлсэн шастир”, “Тоть шувууны сургаал”,
 Хуульч Сандаг “Сайн муу бичээч нарын хэлсэн үг”
 E. “Чингисийн билиг”, “Оюун түлхүүр”, “Тоть шувууны сургаал”, Д.Равжаа “Цаасан шувууны үлгэр”
40. Б.Явуухулангийн яруу найргийн гол онцлог юу вэ?
 А. Улс төрийн уянга В. Утга уянга С. Байгалийн уянга
 D. Сэтгэлзүйн уянга E. Элбэрэл хайрын уянга

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Өгүүлбэрийн цэгийн оронд оновчтой үгийг харгалзуулж сайн морины шинжийг дүрсэлсэн нэгэн цогцолбор бүтээгээрэй. (5 оноо)
- | | |
|-------------------|-----------|
| А. Хөөхөд ... | 1. Сайвар |
| В. Хөтлөхөд... | 2. Дөмөн |
| С. Унахад... | 3. Хурдан |
| D. Уралдахад... | 4. Ороо |
| E. ...сайхан адуу | 5. Номхон |

- 2.2. Хэлц өгүүлбэрийг гол санаатай нь зөв харгалзуулаарай. (5 оноо)
- | | |
|--|---------------------------|
| А. Их санасан газар есөн шөнө хоосон | 1. Хэр хэмжээгээ мэдэхгүй |
| В. Ааг идсэн илжиг адуу даган гүйх | 2. Хоосон сүржигнэх |
| С. Төрөөгүй хүүхдэд төмөр өлгий бэлдэх | 3. Дуусахын даваан дээр |
| Д. Үхэр алаад ахар сүүлэн дээр нь | 4. Үлдэгдэл нь дуусахгүй |
| Е. Их өтөг гурван жил шатдаг | 5. Хэтрүүлэн үнэлэх |
- 2.3. Дараах үгсэд байгаа өгөх оршихын тийн ялгалын нөхцөлийн утгыг нягтлан зөв харгалзуул. (5 оноо)
- | | |
|--------------------------|----------------------------|
| А. Бороонд нэвтэр | 1. Үйлийн цагийн утга |
| В. Цээжиндээ эрдэмтэй | 2. Нэг юм нөгөөд байх утга |
| С. Наранд гялалз | 3. Үйлийн зорилгын утга |
| Д. Шуургатайд оч | 4. Тухайн юманд өртөх утга |
| Е. Албан тушаалд санаарх | 5. Үйлийн шалтгааны утга |
- 2.4. Доорх зохиолуудад юуны тухай голлон өгүүлснийг зөв харгалзуулаарай. (5 оноо)
- | | |
|-----------------------------------|-----------------------------|
| А. Б.Ринчен “Шүхэрч Буняа” | 1. Байгалиа хамгаалах тухай |
| В. Ч.Лодойдамба “Шаргачин” | 2. Сэтгэлийн хатгын тухай |
| С. Д.Намдаг “Үрэгдсэнийг хүлээгч” | 3. Хэл сурах нь чухал тухай |
| Д. Д.Маам “Өндөр Сүхээ гуай” | 4. Хүн чанарын тухай |
| Е. С.Эрдэнэ “Малын хөлийн тоос” | 5. Авьяас сонирхлын тухай |

ХУВИЛБАР D

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Шувуун саарал

Үүрийн хаяа гэгээрэхэд, хөмсөг мэт сар далд ороогүй, дэргэдүүр намрын хяруу гялтганаж, тэртээ уулын орой эрвийн сэрвийн үзэгдэнэ. Гэтэл Сүрэнхүү гэрээс гарч, морио барьж эмээлэн мордоод, баруун зүг одов.

Өглөөний нар гарахад, нэгэнт хэд хэдэн уул, голыг өнгөрчээ. Сүрэнхүү хөндлөн сууж, холхи газрыг зорин, энэ үдэш нэг юманд яарна.

Шувуун саарал нь хазаар даран, хоногийн газрыг өдөрт хүрэхээр тэмүүлэн хатирна.

Явах зам мэлцийм цэлгэр, сайхан намрын үес тул өвсний толгой найгана. Өмнө биеэр хэрэн давхих гөрөөс уг ёсоор цэнгэлдээд, долгион мэт өнгөрнө. Шувуун саарал морь нь Сүрэнхүүгийн унаа, сүүмэлзэн сүүмэлзэн харагдах нь Сүнжидмаагийн нутаг.

Харь хошууны нутагт ороход урьд үзэгдээгүй уул ус бас ч сонин. Үүгээр түүгээр адуу мал зөндөөн бэлчээд, үе үе тохиолдох айлын зэл дээр бариатай гүүнүүд янцгааж, айраг найрын цаг мэдэгдэвч дайран орж зугаацах чөлөө хаана вэ?

(Д. Нацагдорж)

- Эхийн сэдвийг олоорой.

А. Малчин хүний тухай	В. Өглөө нарны тухай	С. Харь нутгийн тухай
Д. Хайр сэтгэлийн тухай	Е. Сэтгэл, зүтгэлийн тухай	
- Эхийн гол санааг олоорой.

А. Орох оронгүй, оочих аягагүй
В. Нойрноос морио, чөмөгнөөс хутгаа
С. Эр хүн зорьсондоо, эмээлт морь харайсандаа
Д. Хайр нь дотроо, хал нь гаднаа
Е. Эр хүний жаргал, эзгүй хээр
- Эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?

А. “Үүрийн хаяа гэгээрэхэд ... баруун зүг одов”, “Өглөөний нар гарахад ... тэмүүлэн хатирна”, “Явах зам ... Сүнжидмаагийн нутаг”, “Харь хошууны нутагт ... зугаацах чөлөө хаана вэ?” гэсэн 4 цогцолбор
В. “Үүрийн хаяа гэгээрэхэд ... баруун зүг одов”, “Өглөөний нар гарахад ... нэг юманд яарна”, “Шувуун саарал нь ... тэмүүлэн хатирна”, “Явах зам ... Сүнжидмаагийн нутаг”, “Харь хошууны нутагт ... зугаацах чөлөө хаана вэ?” гэсэн 5 цогцолбор
С. “Үүрийн хаяа гэгээрэхэд ... зугаацах чөлөө хаана вэ?” гэсэн 1 цогцолбор
Д. “Үүрийн хаяа гэгээрэхэд ... баруун зүг одов”, “Өглөөний нар гарахад ... Сүнжидмаагийн нутаг”, “Харь хошууны нутагт ... зугаацах чөлөө хаана вэ?” гэсэн 3 цогцолбор
Е. “Үүрийн хаяа гэгээрэхэд ... тэмүүлэн хатирна”, “Явах зам ... зугаацах чөлөө хаана вэ?” гэсэн 2 цогцолбор

4. Дээрх эхэд сарыг “... хөмсөг мэт сар ...” хэмээн адилтгасны учир юу вэ?
 А. Мандаж буй сар байсан учир хөмсөгтэй адилтгасан
 В. Үүлтэй тэнгэрийн сар байсан учир хөмсөгтэй адилтгасан
 С. Тэргэл сар байсан учир хөмсөгтэй адилтгасан
 D. Хавирган сар байсан учир хөмсөгтэй адилтгасан
 E. Шингэж амжаагүй сар байсан учир хөмсөгтэй адилтгасан
5. Эхийн хэв маягийг тодорхойл.
 А. Үйл явдлын шинжийг тоочсон тоочимж
 В. Үйл явдлыг цагийн дарааллаар өгүүлсэн хүүрнэмж
 С. Хэрэг явдлын мөн чанарыг тайлбарласан тайбарламж
 D Үр дагаврыг учирлан илэрхийлсэн учирламж
 E. Хэрэг явдлыг эргэцүүлэн бясалгаж дүрсэлсэн эргэцүүлэмж
6. Дээрх эх найруулгын ямар төрөлд хамаарах вэ?
 А. Албан бичгийн В. Ярианы С. Уран зохиолын
 D. Сонин нийтлэлийн E. Эрдэм шинжилгээний
7. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг нөхөөрэй.
 “Аливаа эхийн суурь буюу хуучин мэдээллийг агуулсан хэсгийг мэдээлэл гэнэ.”
 А. Онцолбор В. Дэвсвэр С. Тодосгогч D. Тодотгол E. Гол
8. Дээрх эхийн “...дайран орж зугаацах чөлөө хаана вэ?” гэдэгт ямар баймж үнэлэмж илэрч байна вэ?
 А. Үйл явдлыг лавлан асуусан санаа В. Үйл явдлын хэр хэмжээг үнэлсэн санаа
 С. Үйл явдлыг үгүйсгэсэн санаа D. Үйл явдалд баярлан бахадсан санаа
 E. Үйл явдлыг тааварласан санаа
9. Дараах өгүүлбэрээс шууд тусагдахуун гишүүнийг олоорой.
 Гэтэл Сүрэнхүү гэрээс гарч морио барьж эмээллэн мордоод баруун зүг одов.
 А. Сүрэнхүү В. Гэрээс С. Морио D. Зүг E. Мордоод
10. Үгийн бүтцээр зөв задалсныг олоорой.
 А. Гэг - ээ - рэх - д В. Гэг - ээ - р - Ø - Ø - х - д С. Гэ - гээ - рэ - хэд
 D. Гэгээ - р - Ø - Ø - х - д E. Гэгээр - Ø - Ø - х - д
11. Дээрх эхийн хэрэг явдал ямар цаг хугацаанд өрнөж байна вэ?
 А. Үүрийн гэгээ - өглөөний нар В. Өглөөний нар - үд дунд
 С. Үд дунд - үдшийн бүрий D. Оройн сэрүүн - шөнийн харанхуй
 E. Үүрийн гэгээ - өдрийн нар
12. Дараах холбоо үгсээс аль нь хэлзүйжсэн холбоо үг вэ?
 А. Зэл дээр В. Үүрийн хаяа С. Намрын хяруу
 D. Баруун зүг E. Шувуун саарал
13. Дараах өгүүлбэрийн “гэгээрэхэд” гэсэн үгийг утгаар нь солин найруулбал аль үг хамгийн ойр байж болох вэ?
 Үүрийн хаяа гэгээрэхэд, хөмсөг мэт сар далд ороогүй, дэргэдүүр намрын хяруу гялтганаж, тэртээ уулын орой эрвийн сэрвийн үзэгдэнэ.
 А. Мандахад В. Цайхад С. Шарлахад
 D. Тэмдэгрэхэд E. Хяраалахад
14. Дараах өгүүлбэрийг салаалан хувиргасныг олоорой.
 Шувуун саарал морь нь Сүрэнхүүгийн унаа, сүүмэлзэн сүүмэлзэн харагдах нь Сүнжидмаагийн нутаг.
 А. Ташаа нь тэвхийж, хавирганы яс нь зураисан шувуун саарал морь нь нүдэндээ галтай залуу эр Сүрэнхүүгийн унаа, тэртээ алсын униар дунд сүүмэлзэн сүүмэлзэн харагдах нь нүүрэндээ гэрэлтэй залуу хүүхэн Сүнжидмаагийн нутаг.
 В. Сүүмэлзэн сүүмэлзэн харагдах нь Сүнжидмаагийн нутаг, шувуун саарал морь нь Сүрэнхүүгийн унаа.
 С. Сүрэнхүүгийн унаа, Сүнжидмаагийн нутаг.
 D. Буган хул ажнай нь буянтай аавын минь унаа, будан дунд сүүмэлзэх нь буурал ээжийн минь нутаг.
 E. Шувуун саарал морь нь Сүрэнхүүгийн унаа, сүүмэлзэн сүүмэлзэн харагдах нь Сүнжидмаагийн нутаг. Холоос гүйдэлтэй саарал нь хоногийн газрыг товчлоход хоёр сэтгэлийн дунд зулын гэрэл бадамлана.
15. Дараах өгүүлбэрийн онцлон тодруулсан хэсгийн бүтцийг тодорхойл.
Өглөөний нар гарахад нэгэнт хэд хэдэн уул, голыг өнгөрчээ.
 А. Дүрийн байц гишүүн өгүүлбэр В. Цагийн байц гишүүн өгүүлбэр
 С. Шалтгааны байц гишүүн өгүүлбэр D. Орны байц гишүүн өгүүлбэр
 E. Байдал заасан байц гишүүн өгүүлбэр

16. Дээрх (15-р) өгүүлбэрийн хоёр бүрэлдэхүүнт цөм бүтцийг зөв тодорхойлсныг ол.
А. Уул, гол В. Өглөөний нар С. Нар гарах
D. Хэд, хэдэн E. Голыг өнгөр
17. Эхээс түүвэрлэсэн дараах үгсийн утгын зүйлчлэлд хамааралгүй үгийг олоорой.
Сар, хяруу, нар, уул, гол, газар, зам, өвс, нутаг
А. Сар В. Нар С. Уул D. Гол E. Өвс
18. Дараах өгүүлбэрийн үйл явдлыг цагийн дарааллаар холбох үүрэгтэй бүтээврийг зөв бүлэглэснийг олоорой.
Гэтэл Сүрэнхүү гэрээс гарч, морио барьж эмээллэн мордоод, баруун зүг одов.
А. -л, -ч, -ж, -н В. -ч, -ж, -н, -оод С. -ээс, -ч, -ж, -оод
D. -оо, -ж, -н, -оод E. -тэл, -ээс, -оо, -в
19. Эхээс түүвэрлэсэн өгүүлбэрүүдээс “яаран тэмүүлэх” гэсэн санаа илэрхийлээгүй өгүүлбэрийг олоорой.
А. Морио барьж эмээллэн мордоод, баруун зүг одов.
B. Холхи газрыг зорин энэ үдэш нэг юманд яарна.
C. Үүгээр түүгээр адуу мал зөндөө бэлчинэ.
D. Хонгийн газрыг өдөрт хүрэхээр тэмүүлэн хатирна.
E. Дайран орж зугаацах чөлөө хаана вэ?
20. Дараах өгүүлбэрт жинхэнэ нэрийн тийн ялгалын нөхцөлтэй үг хэд байна вэ?
Харь хошууны нутагт ороход урьд үзэгдээгүй уул ус бас ч сонин.
А. 5 В. 6 С. 7 D. 8 E. 9
21. Утгын алдаатай үүсгэсэн холбоо үгийг олоорой.
А. Хурганы арьс В. Тэмээний шир С. Үхрийн шир
D. Ямааны шир E. Адууны шир
22. Дээрх эхээс авсан холбоо үгсийг ажиглаад адил бүтэц үүрэгтэй үгийг олоорой.
Морио барь, морио эмээллэ, голыг өнгөр, газрыг зорь, хазаар дар
А. Хаяа гэгээр В. Уулын орой С. Явах зам,
D. Мал бэлч E. Уул үз
23. Бүгд үйлийн хам холбох “-н” нөхцөлтэй үг орсон хэсгийг олоорой.
А. Намрын, уулын, эрвийн В. Эмээллэн, баруун, хэдэн
C. Зорин, шувуун, даран D. Сүүмэлзэн, дайран, яаран
E. Сонин, сайхан, найган
24. Доорх таван үгээс төрөл бишийг олж тэмдэглэ.
А. Сурлага В. Суурин С. Сургууль
D. Сурамгай E. Сургагч
25. Дараах өгүүлбэрт харь үг хэрэглэснийг юу гэж үзэх вэ? Зөв хариултыг ол.
“Интернэт гэдэг нь компьютерийн хамгийн том сүлжээ юм”
А. Зарим тохиолдолд орчуулгагүй авч болно
B. Зөвхөн ярианд л орчуулгагүй авч болно
C. Харь үгийг монгол үгтэй хольж хэрэглэхгүй
D. Монгол хэл мөхөх аюултай учир заавал орчуулах хэрэгтэй
E. Олон улсын чанартай үгсийг орчуулгагүй хэрэглэж болно
26. Үгийн аймгаар зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
А. Хаяа, хөмсөг, сар, далд, намар, хяруу В. Уул, орой, гэр, морь, барь, эмээл
C. Зүг, хэд, гол, суу, холхи, нэг D. Хазаар, газар, өвс, толгой, гөрөөс, долгион
E. Өглөө, адуу, дээр, дайр, хаана, цэлгэр
27. “Суух” гэдэг үгийн салаа утгат үгсээс доорх тайлбарт тохирох хэсгийг олоорой.
Үгийн тайлбар нь: наалдах, тогтох, наалдан тогтох
А. Ноён суух В. Утаа суух С. Тэрэг суух
D. Ялаа суух E. Хуралд суух
28. Дээрх эхэд байгаа “мэлцийм цэлгэр” хэмээх холбоо үгтэй бүтцээрээ адил загвартай үгийг олоорой.
А. Шатаам халуун В. Уужим бодол С. Уудам тал
D. Аажим аажмаар E. Дөхөм газар
29. Крилл монгол бичгийн цагаан толгойд авиа тэмдэглэдэггүй үсэг хэд байдаг вэ?
А. 9 В. 7 С. 6 D. 4 E. 2
30. 3 үсэг, 2 авианаас бүтсэн үгийг олоорой.
А. Хар В. Хай С. Хол D. Зэх E. Гох
31. Дараах өгүүлбэрийн таслалыг хасвал санаа нь өөрчлөгдөх үү? Зөв хариултыг олоорой.
“Өнөөдөр, танай өгсөн айргийг уусан”

- А. Гишүүдийн байр хэвээрээ тул өөрчлөгдөхгүй
 В. Өгүүлбэрийн санаа өөрчлөгдөхгүй
 С. Зөвхөн бүтэц нь өөрчлөгдөнө
 D. Өгүүлбэрийн санаа өөрчлөгдөнө
 E. Өгүүлэхүүний утга л өөрчлөгдөнө
32. Үйл үг үүсгэх “-л” дагавар залгахад аль үг нь бусдаасаа өвөрмөц бичигдэх вэ?
 А. Тав В. Нэр С. Цоож D. Нутаг E. Сум
33. Бүгдийг зөв бичсэн хэсгийг олоорой.
 А. Уншъя, хэлье, идье В. Өгөө, үзье, бичье С. Олоё, харъя, мэдэе
 D. Зурая, хадая, нэмэе E. Явъя, тосъё, босоё
34. Дараах өгүүлбэрийг крилл бичигт зөв хөрвүүлснийг олоорой.
 А. Тийн хүний хамаг эрдмийн дотор Нигүүлсэхүй сэтгэл нэн эрдэм
 В. Тийн хүний хамаг эрдмийн дээр Нигүүлсэхүй сэтгэл нэн эрдэм
 С. Тойн хүний хамаг эрдмийн дотор Нийлсэхүй сэтгэл нэг эрдэм
 D. Тойн хүний хамаг эрдмийн дотор Нигүүлсэхүй сэтгэл нэн эрдэм
 E. Тойн хүний хамаг эрдмийн дотор Нийлсэхүй итгэл нэн эрдэм
35. Монгол бичигт үйлээс нэр үг бүтээх “**ᠮᠣᠩᠭᠣᠯ**” дагавар авах үгийг олоорой.
 А. Түл В. Хэл С. Нис D. Хүр E. Зал
36. Нэрийн тийн ялгалын нөхцөлөөр буруу хувилгасныг олоорой.
 А. **ᠠᠨᠠ** **ᠮᠠ** В. **ᠠᠨ** **ᠮᠠ** С. **ᠠᠨ** **ᠮᠠ** D. **ᠠᠨ** **ᠮᠠ** E. **ᠠᠨ** **ᠮᠠ**
37. Монгол бичгээр богино эгшгийг уртаар тэмдэглэдэг үгийг олоорой.
 А. Дэл В. Хэл С. Гол D. Бал E. Сөл
38. “Монголын Нууц Товчоон” зохиолд Чингис хааны “хавт” хэмээн өргөмжлөгдсөн дүүг:
 “... Гурван бухаар зүтгүүлэвч, гулзайхгүй хүчтэй
 Гунжин үхрийг идэвч, цадахгүй ходоодтой ...” гэхчлэн уран яруу шүлэглэсэн байдаг. Энэ дүр хэн бэ?
 А. Боорчи В. Хасар С. Отчигин
 D. Бэлгүтэй E. Бэгтэр
39. Доорх зохиолуудын дарааллыг ажиглаад зөв зүй тогтлыг олоорой.
 А. “Чингисийн билиг”, “Оюун түлхүүр”, “Мандухай сэцэн хатны домог”, “Хурдан морины цол”
 В. Ц.Дамдинсүрэн “Чөтгөр”, Д.Нацагдорж “Ламбугайн нулимс”, Ш.Сүрэнжав “Багш”,
 Г. Сэр-Од “Дөмөн”
 С. Ч.Лхамсүрэн “Хүрэн морь”, Г.Сэр-Од “Дөмөн”, Ш.Сүрэнжав “Багш”, О.Дашбалбар
 “Амьддаа бие биеэ хайрла, хүмүүс ээ!”
 D. “Эр хоёр загалын тууж”, “Өнчин хүүгийн цэцэлсэн шастир”, Д.Пүрэвдорж “Сэгс цагаан богд”,
 Ч.Лхамсүрэн “Хүрэн морь”
 E. Ч.Лхамсүрэн “Хүрэн морь”, Д.Пүрэвдорж “Сэгс цагаан богд”, Ш.Сүрэнжав “Багш”, Ц.Гайтав
 “Дамдины Сүхбаатар”
40. Д.Пүрэвдоржийн найраглалуудын гол онцлог нь юу вэ?
 А. Уран хурц дүрслэл В. Бодрол бясалгалын аяс
 С. Гүн ухаанч чанар D. Хүүрнэсэн тоочилт
 E. Утга далдалсан шинж

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Өгүүлбэрийн цэгийн оронд оновчтой үгийг харгалзуулж хурдан морины шинжийг дүрсэлсэн нэгэн цогцолбор бүтээгээрэй. (5 оноо)
- | | |
|-----------------------------|------------------|
| А. Заамал зургаан хүзүүг... | 1. Самбалзуулсан |
| В. Төө сайхан чихийг ... | 2. Сагсалзуулсан |
| С. Туулай сайхан зоог... | 3. Суналзуулсан |
| D. Шашир сайхан дэлийг... | 4. Хотолзуулсан |
| E. Шанам сайхан сүүлийг... | 5. Солбилзуулсан |

2. 2. Хэлц өгүүлбэрийг гол санаатай нь зөв харгалзуулаарай. (5 оноо)
- | | |
|---------------------------------------|----------------------------|
| А. Хүний юм хүрэнгийн махнаас заартай | 1. Бүтээхээсээ бүрэлгэх нь |
| В. Муу дархны нүүрс их | 2. Долоон дордуулах |
| С. Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушги | 3. Санаа дагах |
| Д. Нуухы нь авах гээд нүдий нь сохлох | 4. Бусдынх чанаргүй |
| Е. Айсан хүнд аргал хөдөлнө | 5. Цаг хугацаа чухал |
2. 3. Дараах үгсэд байгаа үйлдэхийн тийн ялгалын нөхцөлийн утгыг нягтлан зөв харгалзуул. (5 оноо)
- | | |
|---------------------|-----------------------------|
| А. Хөрөөгөөр хөрөөд | 1. Хамтран дагалдах утга |
| В. Торгоор эсгэ | 2. Үйлийн шалтгааны утга |
| С. Олзоор баяж | 3. Үйлийн цагийн утга |
| Д. Хониноор яв | 4. Үйлийн бүтэх юмын утга |
| Е. Нарнаар бос | 5. Үйлдэх хэрэглүүрийн утга |
2. 4. Доорх зохиолуудад юуны тухай голлон өгүүлснийг зөв харгалзуулан олоорой. (5 оноо)
- | | |
|----------------------------------|------------------------------------|
| А. Д.Равжаа “Үлэмжийн чанар” | 1. Төр, шашны тухай |
| В. Р.Хишигбат “Хос морин сайвар” | 2. Говийн дотоод мөн чанарын тухай |
| С. Д.Нацагдорж “Миний нутаг” | 3. Хүний таван мэдрэхүйн тухай |
| Д. Б.Явуухулан “Товь” | 4. Монгол нутгийн тогтоцын тухай |
| Е. Б.Лхагвасүрэн “Товь” | 5. Говийн гадаад мөн чанарын тухай |

ХУВИЛБАР Е**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ****Хөдөө талын үзэсгэлэн**

Ийшээ ширтэж, тийшээ гөлрөн, үүнийг гайхаж, түүнийг бодсоор явтал, олон морьтой хүмүүсийн дундуур нэгэн сайхан саарал морины толгой тэмүүлэн, ам нь ангалзаж, хоёр чих нь солбилзон үзэгдэхүй дор хэдий миний хоёр нүдэн гэрэлтэн тусав. Нэгэн залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэхүй нь зэрлэг бугын адил өнгөтэй ба цог заль гэрэлтэн, жавхлантай нь түмэн баатар эрийн боловч зүрхийг чичрүүлэн догдлуулж, төв эрдэмт оюутны боловч хүслийг холбилзуулан татна. Цагаан саарал морины нуруун дээр ногоон гөлөмтэй боржгин янзын эмээлийг тохсон нь холхи газрын хүлгийн өнгө ялгаран үзэсгэлэн бүрдээд, түүний дээр залуу охин хормойг цэмцийтэл, гуяыг мөлчийлгөн ороогоод, хөндлөн суужээ. Үзвээс нас арван найм ес, шинэ сарны адил хурц тунгалаг гэрэлтэнэ. Урт хар гэзгийг гурваар даран унжуулж, улбар шар дурдан алчуураар толгойгоо ороон, өрөөсөн нүдний дээд тал дээр хэлтгий зангилан үзүүрийг унжуулсан нь залуу бүсгүйн дэгжин байдлыг үзүүлжээ. Цайвар өнгөтэй зөөлөн царай нь зуны наран дор борлоод хоёр хацарт нь эрүүлийн улаан туяа тусжээ. Харах нүдний хар цагаан нь хослоод, хотын залуу хүний дээр эелдгээр хөдлөх тутам миний нүд эрх үгүй дагалдан давхина.

(Д. Нацагдорж)

1. Эхийн сэдвийг олоорой.
- | | | |
|--------------------------|------------------------|----------------------|
| А. Малчин эмэгтэйн тухай | В. Гоо сайхны тухай | С. Залуу насны тухай |
| Д. Баяр наадмын тухай | Е. Сайхан морины тухай | |
2. Эхийн гол санааг олоорой.
- | | |
|--|--|
| А. Эдээр биеэ чимэхээр, эрдмээр биеэ чим | В. Нийлсэн хоёр сэтгэл нь мянган лан алт шиг |
| С. Хүний сайныг ханилан байж мэднэ | Д. Сайхан бүсгүй гэрийн чимэг |
| Е. Эрүүл биед саруул ухаан оршино | |
3. Эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?
- А. “Ийшээ ширтэж, тийшээ гөлрөн ... хүслийг холбилзуулан татна”, “Цагаан саарал морины ... дэгжин байдлыг үзүүлжээ”, “Цайвар өнгөтэй зөөлөн царай нь ... дагалдан давхина” гэсэн 3 цогцолбор
- В. “Ийшээ ширтэж, тийшээ гөлрөн ... дэгжин байдлыг үзүүлжээ”, “Цайвар өнгөтэй зөөлөн царай нь ... дагалдан давхина” гэсэн 2 цогцолбор
- С. “Ийшээ ширтэж, тийшээ гөлрөн ... дагалдан давхина” гэсэн 1 цогцолбор
- Д. “Ийшээ ширтэж, тийшээ гөлрөн ... гэрэлтэн тусав”, “Нэгэн залуу хүүхэн ... дэгжин байдлыг үзүүлжээ”, “Цайвар өнгөтэй зөөлөн царай нь ... дагалдан давхина” гэсэн 3 цогцолбор
- Е. “Ийшээ ширтэж, тийшээ гөлрөн ... хүслийг холбилзуулан татна”, “Цагаан саарал морины ... хурц тунгалаг гэрэлтэнэ”, “Урт хар гэзгийг ... дэгжин байдлыг үзүүлжээ”, “Цайвар өнгөтэй зөөлөн царай нь ... дагалдан давхина” гэсэн 4 цогцолбор

4. Дээрх эхэд саарал морьтой бүсгүйг “... шинэ сарны адил хурц тунгалаг гэрэлтэнэ” хэмээн дүрсэлсний учир юу вэ?
 А. Залуу бүсгүй цог жавхаатай байсан учир
 В. Залуу бүсгүй дугуй нүүртэй байсан учир
 С. Залуу бүсгүй арван найм естэй байсан учир
 D. Залуу бүсгүй сайхан морьтой явсан учир
 E. Залуу бүсгүй онцгой сайхан байсан учир
5. Эхийн хэв маягийг тодорхойл.
 А. Үйл явдлын шинжийг тоочсон тоочимж
 В. Үндэслэл дэвшүүлж нотолж баталсан эргэцүүлэмж
 С. Хэрэг явдлыг хялбаршуулан тайлбарласан тайбарламж
 D. Үр дагаврыг учирлан илэрхийлсэн учирламж
 E. Үйл явдлыг урнаар өгүүлсэн хүүрнэмж
6. Дээрх эх найруулгын ямар төрөлд хамаарах вэ?
 А. Албан бичгийн
 В. Ярианы
 С. Уран зохиолын
 D. Сонин нийтлэлийн
 E. Эрдэм шинжилгээний
7. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг нөхөөрэй.
 “Аливаа эхийн хуучин мэдээллийг тодосгон өгүүлсэн шинэ мэдээллийг ... мэдээлэл гэнэ”
 А. Дэлгэрүүлэгч
 В. Дэвсвэр
 С. Тодотгол
 D. Онцолбор
 E. Гол
8. Дээрх эхийн “...миний нүд эрхгүй дагалдан давхина” гэдэгт ямар баймж үнэлэмж илэрч байна вэ?
 А. Үйл байдалд дургүйцсэн санаа
 В. Үйл байдлыг тааварлан лавласан санаа
 С. Үйл байдал сэтгэлд зохистой илэрхийлсэн санаа
 D. Үйл байдлыг дурсан дурдсан санаа
 E. Үйл байдалд эргэлзэх санаа
9. Дараах өгүүлбэрээс өгүүлэгдэхүүн гишүүнийг олоорой.
 Цайвар өнгөтэй зөөлөн царай нь зуны наранд борлоод хоёр хацарт нь эрүүлийн улаан туяа тусчээ.
 А. Зөөлөн
 В. Царай нь
 С. Хацарт нь
 D. Улаан
 E. Зуны
10. Үгийн бүтцээр зөв задалсныг олоорой.
 А. Үз-гд-Ø-х-д
 В. Үзэг-д-Ø-х-д
 С. Үзэгд-х-Ø-д
 D. Ү-зэг-дэ-хэд
 E. Үз-гд-Ø-Ø-х-д
11. Дээрх эхэд “ийшээ ширтэж, тийшээ гөлрөн” хэмээн дүрсэлсэн нь ямар утга санаатай вэ?
 А. Үйл байдлын эсрэг санаа
 В. Орон байрын эсрэг санаа
 С. Цаг хугацааны эсрэг санаа
 D. Шинж тэмдгийн эсрэг санаа
 E. Юмс үзэгдлийн эсрэг санаа
12. Дараах холбоо үгсээс аль нь үгийн санжсан холбоо үг вэ?
 А. Залуу хүүхэн
 В. Хар гээг
 С. Хоёр нүд
 D. Хүмүүсийн дунд
 E. Цог заль
13. Дараах өгүүлбэрийн “арван найм ес” гэсэн үгийг утгаар нь солин найруулбал аль үг хамгийн ойр байж болох вэ?
 Үзвээс нас арван найм ес, шинэ сарны адил хурц тунгалаг гэрэлтэнэ.
 А. Арван найм
 В. Арван найм орчим
 С. Арван найм эргэм
 D. Хориод
 E. Арван долоогоос арван найм
14. Дараах өгүүлбэрийг хураан хувиргасан хувиргалыг олоорой.
 Цайвар өнгөтэй зөөлөн царай нь зуны наранд борлоод хоёр хацарт нь эрүүлийн улаан туяа тусжээ.
 А. Тос даасан хүрэн царайд нь олон оны нар салхины гэрэл сүүдэр нэвчин шингэсэн ч залуугийн цог заль хэвээр үлджээ.
 В. Эрүүлийн улаан туяа хоёр хацарт туссан нь цайвар өнгөтэй зөөлөн царай нь зуны наранд борлосных.
 С. Царай нь борлоод туяа тусжээ.
 D. Нар атаархаж, сар далдирам цайвар өнгөтэй торгон зөөлөн нүүр царай нь бороо хуртай тэгш сайхан зуны наранд тос даан борлоод хоёр хацарт нь эрүүл саруулын улаан ягаан туяа тусжээ.
 E. Хоёр хацарт нь эрүүлийн улаан туяа туссан нь цайвар өнгөтэй зөөлөн царай нь зуны наранд борлосных.
15. Дараах өгүүлбэрийн онцлон тодруулсан хэсгийн бүтцийг тодорхойл.
Харах нүдний хар цагаан нь хослоод, хотын залуу хүний дээр эелдгээр хөдлөх тутам дор миний нүдэн эрхгүй дагалдан давхина.
 А. Дүрийн байц гишүүн өгүүлбэр
 В. Цагийн байц гишүүн өгүүлбэр
 С. Шалтгааны байц гишүүн өгүүлбэр
 D. Орны байц гишүүн өгүүлбэр
 E. Байдал заасан байц гишүүн өгүүлбэр

16. Дээрх (15-р) өгүүлбэрийн гурван бүрэлдэхүүнт цөм бүтцийг зөв тодорхойлсныг ол.
А. Нүд дага В. Нүд давхи С. Нүдний цагаан
D. Нүд хосол E. Түүний нүд
17. Эхээс түүвэрлэсэн дараах үгсийн утгын зүйлчлэлд хамааралгүй үгийг олоорой.
Ширт, гөлөр, гайх, солбилз, бод, догдол, чичир
А. Бод В. Гайх С. Догдол D. Солбилз E. Ширт
18. Дараах өгүүлбэрийн үйл байдлыг зэрэгцүүлэн холбох үүрэгтэй бүтээврийг зөв бүлэглэснийг олоорой.
Урт хар гэзгийг гурваар даран унжуулж, улбар шар дурдан алчуураар толгойгоо ороон, өрөөсөн нүдний дээд тал дээр хэлтгий зангидан унжуулсан нь залуу бүсгүйн дэгжин байдлыг үзүүлжээ.
А. -ийг, -н В. -ж, -сан С. -ж, -н, D. -н, -нь E. -ыг, -жээ
19. Эхээс түүвэрлэсэн өгүүлбэрүүдээс “сайхныг бахдан бишрэх” санаа илэрхийлээгүй өгүүлбэрийг олоорой.
А. Нэгэн залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэв.
В. Түмэн баатар эрийн боловч зүрхийг чичрүүлэн догдлуулж.
С. Төв эрдэмт оюутны боловч хүслийг холбилзуулан татна.
D. Шинэ сарны адил хурц тунгалаг гэрэлтэнэ.
E. Зэрлэг бугын адил өнгөтэй ба цог заль гэрэлтэнэ.
20. Дараах өгүүлбэрт жинхэнэ нэрийн тийн ялгалын нөхцөлтэй үг хэд байна вэ?
Цайвар өнгөтэй зөөлөн царай нь зуны наранд борлоод хоёр хацарт нь эрүүлийн улаан туяа тусжээ.
А. 5 В. 6 С. 7 D. 8 E. 9
21. Дараах үгсээс утгаараа буруу холбогдсон үгийг ол.
А. Зүрхийг амраа В. Зүрхийг чичрүүл С. Зүрхийг догдлуул
D. Зүрхийг өвтгө E. Зүрхийг хөдөл
22. Дараах холбоо үгсийг ажиглаад холбогдох арга, бүтцээрээ бусдаасаа ялгаатай үгийг олоорой.
А. Цагаан саарал морь В. Хотын залуу хүн С. Улбар шар алчуур
D. Урт хар гэзэг E. Хурц тунгалаг гэрэл
23. Бүгд үйлийн хам холбох “-н” нөхцөлтэй үг орсон хэсгийг олоорой.
А. Олон, нэгэн, сайхан В. Хэдийн, нүдэн, гэрэлтэн
С. Гөлрөн, тэмүүлэн, солбилзон D. Дугтран, чичрүүлэн, нуруун
E. Хөндлөн, даран, дурдан
24. Доорх таван үгээс төрөл бишийг олж тэмдэглэ.
А. Жавхлан В. Жавхайсан С. Жавхаа
D. Жавар E. Жавхгар
25. Өгүүлбэрт этгээд, бүдүүлэг үг хэрэглэснийг хэрхэн дүгнэж байна вэ? Зөв хариултыг олоорой. (утсаар)
- Байна уу? Чуука байна аа? Яачихав аа балай минь. Нөгөө хоёр хулгайчаа түргэл гэж хэлээч цөмөөрөө шалавхан нийлээд хамчихъя. (Ж.Барамсай)
А. Бүгд монгол хэлний үгийн сангийн үг байгаа учир зөв
В. Утга зохиолын хэлний хэм хэмжээг зөрчдөг үгс
С. Найз нөхдийн харилцаанд хэрэглэх нь зөв
D. Уур уцаар сэтгэл хөдлөлөөс бүдүүлэг үгийг хэлж болно
E. Өдөр тутмын харилцаанд хэрэглэгдэх ёстой үгс
26. Үгийн аймгаар зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
А. Хаяа, хөмсөг, сар, далд, намар, хяруу В. Уул, орой, гэр, морь, барь, эмээл
С. Хазаар, газар, өвс, толгой, гөрөөс, долгион D. Зүг, хэд, гол, суу, холхи, нэг
E. Өглөө, адуу, дээр, дайр, хаана, цэлгэр
27. “Гарах” гэдэг үгийн салаа утгат үгсээс доорх тайлбарт тохирох хэсгийг олоорой.
Үгийн тайлбар нь: гатлах, гэтлэх, нэвтрэх, туулах
А. Нөхөрт гарах В. Сонинд гарах С. Ууланд гарах
D. Гэдэс гарах E. Хил гарах
28. Дээрх эхэд байгаа “*нарийхан хуруу*” хэмээх холбоо үгтэй утга, бүтцээрээ адил үгийг олоорой.
А. Ганцхан ээж В. Тэрхэн үе С. Жижигхэн бие
D. Эзгнэнхэн төрлөө E. Дээхэн тал
29. Монгол хэлний цагаан толгойд онцгой гийгүүлэгч үсэг хэд байдаг вэ?
А. 9 В. 7 С. 6 D. 4 E. 2
30. Дараах өгүүлбэрийн таслалыг хасвал санаа нь өөрчлөгдөх үү? Зөв хариултыг олоорой.
“Өнөөдөр, танай өгсөн айргийг уусан”
А. Гишүүдийн байр хэвээрээ тул өөрчлөгдөхгүй
В. Өгүүлбэрийн санаа өөрчлөгдөхгүй С. Зөвхөн бүтэц нь өөрчлөгдөнө
D. Өгүүлэхүүний утга л өөрчлөгдөнө E. Өгүүлбэрийн санаа өөрчлөгдөнө

31. 3 үсэг, 2 авианаас бүтсэн үгийг олоорой.
 А. Хар В. Хай С. Хол D. Зэх E. Гох
32. Бүгдийг зөв бичсэн хэсгийг олоорой.
 А. Уншъя, хэлье, идье В. Өгөө, үзье, бичье С. Олоё, харъя, мэдэе
 D. Зурая, хадаа, нэмэе E. Явъя, тосъё, босоё
33. Үйл үг үүсгэх “-л” дагавар залгахад аль үг нь бусдаасаа өвөрмөц бичигдэх вэ?
 А. Тав В. Бат С. Хар D. Нутаг E. Сум
34. Дараах өгүүлбэрийг крилл бичигт зөв хөрвүүлснийг олоорой.
 А. Хаан хүний гучин таван эрдмийн дотор
 Хайрлах итгэл нэн эрдэм
 В. Хаан хүний гучин таван эрдмийн дотор
 Хайрлах сэтгэл нэн эрдэм
 С. Хаан хүний гучин таван эрдмийн доор
 Хайрлах сэтгэл нэн эрдэм
 D. Хаан хүний гучин таван эрдэнийн дотор
 Хайрлах сэтгэл нэг эрдэм
 E. Хаан хүний гучин таван эрдмийн дотор
 Хайлах сэтгэл нэг эрдэм
35. Монгол бичгээр богино эгшгийг уртаар тэмдэглэдэг үгийг олоорой.
 А. Дэл В. Хэл С. Гол D. Бал E. Сөл
36. Нэрийн тийн ялгалын нөхцөлөөр буруу хувилгасныг олоорой.
 А. ᠠᠨᠳᠠᠯ В. ᠬᠡᠯ С. ᠭᠣᠯ D. ᠪᠠᠯ E. ᠰᠡᠯ
37. Монгол бичигт үйлээс нэр үг бүтээх “ᠨᠢᠰ” дагавар авах үгийг олоорой.
 А. Түл В. Хэл С. Нис D. Хүр E. Зал
38. “Турван зуун тайчуудыг дарсан домог” зохиолд Чингис хаан өөрийн есөн өрлөгийн нэгийг:
 Намайг залуу байх цагт, найман шаргыг эрэх үед
 Наран ургах хирд, надтай уулзсанаас хойш
 Насад үнэнээр зүтгэсэн, Наху баяны хөвүүн ... хэмээн магтсан байдаг. Энэ хэний дүр вэ?
 А. Мухулай В. Борохул С. Зэлмэ D. Зэв E. Боорчи
39. Доорх зохиолуудын дарааллыг ажиглаад, зөв зүй тогтлыг олоорой.
 А. “Мандухай сэцэн хатны домог”, “Оюун түлхүүр”, Ч.Лхамсүрэн “Хүрэн морь”,
 Ч.Чимид “Би монгол хүн”
 В. Ц.Дамдинсүрэн “Чөтгөр”, Д.Нацагдорж “Од”, Ш.Сүрэнжав “Багш”, О.Дашбалбар
 “Амьдаа бие биеэ хайрла, хүмүүс ээ!”
 С. Д.Нацагдорж “Од”, Г.Сэр-Од “Дөмөн”, Б.Явуухулан “Мөнгөн хазаарын чимээ”,
 О.Дашбалбар “Амьдаа бие биеэ хайрла, хүмүүс ээ!”
 D. “Эр хоёр загалын тууж”, “Өнчин хүүгийн цэцэлсэн шастир”, Д.Пүрэвдорж “Сэгс цагаан
 богд”, Ч.Лхамсүрэн “Хүрэн морь”
 E. Цогт “Дуутын хадны шүлэг”, Д.Пүрэвдорж “Сэгс цагаан богд”, Ш.Сүрэнжав “Багш”,
 Ц.Гайтав “Дамдины Сүхбаатар”
40. Б.Лхагвасүрэнгийн яруу найргийн гол онцлог нь юу вэ?
 А. Утга уянгын шинж В. Үгийн өвөрмөц уран сонголт
 С. Улс төр, иргэний магтаал D. Хүүрнэсэн тоочилт
 E. Учирлан тайлбарласан шинж

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Өгүүлбэрийн цэгийн оронд оновчтой үгийг харгалзуулж хурдан морины шинжийг дүрсэлсэн нэгэн цогцолбор бүтээгээрэй. (5 оноо)
- | | |
|----------------------|-------------|
| А. Сунагар өргөн... | 1. Дэлтэй |
| В. Туулай сайхан ... | 2. Сүүлтэй |
| С. Тунамал сайхан... | 3. Зоотой |
| Д. Тунсаг сайхан... | 4. Биетэй |
| Е. Тухлаг бадриун... | 5. Ташаатай |

2. 2. Хэлц өгүүлбэрийг гол санаатай нь зөв харгалзуулаарай. (5 оноо)
- | | |
|-----------------------------------|----------------------|
| А. Хашин моринд газар хол | 1. Өөрөө өөртөө зөв |
| В. Саваагүй нохой саранд хуцах | 2. Байгаа хэрээрээ |
| С. Ямааны айраг лонхондоо исгэлэн | 3. Хийх юмгүй |
| Д. Гайхахдаа дуулах | 4. Сэтгэлээрээ ядрах |
| Е. Адууныхаа хэрээр исгэрэх | 5. Хоосон санаархах |
2. 3. Дараах үгсэд байгаа гарахын тийн ялгалын нөхцөлийн утгыг нягтлан зөв харгалзуул. (5 оноо)
- | | |
|-------------------|-----------------------------|
| А. Багаасаа ухаар | 1. Салах холдох утга |
| В. Дээрээс эхэл | 2. Бүхлийн хэсэг болох утга |
| С. Талхнаас ид | 3. Үйлийн шалтгааны утга |
| Д. Уснаас гар | 4. Эхлэх цагийн утга |
| Е. Чамаас боллоо | 5. Үйлийн үүсэх орны утга |
2. 4. Доорх зохиолуудад юуны тухай голлон өгүүлснийг зөв харгалзуулан олоорой. (5 оноо)
- | | |
|---|-----------------------------------|
| А. Ц.Дамдинсүрэн “Зугаацахаар мордсон нь” | 1. Төрсний эцэст үхдэг тухай |
| В. Б.Явуухулан “Тэхийн зогсоол” | 2. Дайны хор хөнөөлийн тухай |
| С. Д.Пүрэвдорж “Хар цас” | 3. Байгалийн сайхны тухай |
| Д. Ч.Лхамсүрэн “Хүрэн морь” | 4. Гоймон баатарын тухай |
| Е. Ц.Гайтав “Дамдины Сүхбаатар” | 5. Хүүхдийн дүрийн өсөлтийн тухай |

ХУВИЛБАР G

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ


Адууны манаанд

Үүрийн цагаан гэгээ тусмагц хөхөө шувуу урьханаар донгодох дуу уулын цуурай ба салхины аятай хослон өргөн талд дэлгэрэнгүйгээ хангинаж, яруухнаар дуурсмагц адуугаа манаж байсан залуу хүү Цогт агшин зуур дугхийсэн нойрноос сэрэн босож, тавтайхнаар эвшээн суниагаад, гарынхаа араар нүдээ арчин, дөрвөн зүгт хандвал энэ үе сайхан зуны тэргүүн сарын шинэд тул дэлхийн бодис ба цагийн улирал үнэхээр тааламжтай. Хөх тэнгэр тунгалагаар цэлмээд, хөвөн үүл хэсэг хэсгээр тунана. Дэргэдэх ургамал, цэцгэнд нимгэн цагаан хяруу гилтгэнээд, тэртээ ой модонд ногооны униар залгалдана. Урьхан салхи зөөлнөөр найгаад, ариун агаар цээж дүүрэн амьсгалуулна. Удалгүй дүгрэг том нар мандан гарч ирэхэд баруун ба хойд уулын орой ба энгэрээр гэрэл тусаад, өмнөх их талд туяа нийтлэн шарлав. Үүнд Цогт хүү нэг зэрэг бахдаад, их л баясгалантай байдлаар гялбалзан, уурга тулж мордон, адууныхаа дэргэд хүрвэл, олон адуу нь нэгэнт ханаад, шилгээх нь шилгээж, хөрвөөх нь хөрвөөж, шарвах нь шарваж, зарим нь эвшээн, зарим нь янцгаан, зарим нь годгонон, энд тэнд хэвтэж, хол ойр зогсож, нааш цааш явж байна. Энтээ тэнтээ хажуугаар нь эргэлдэн шогшиж, хэдэнтээ хашхирмагц адуу бүгдээрээ хөдлөн хурав. (Д. Нацагдорж)

1. Эхийн сэдвийг олоорой.
- | | |
|-------------------------------------|---------------------------------|
| А. Адуучин хүний ажил үйлсийн тухай | В. Цаг улирлын өнгө аясын тухай |
| С. Хүний амьдралын тухай | Д. Байгалийн сайхны тухай |
| Е. Өдөр солигдох тухай | |
2. Эхийн гол санааг олоорой.
- | | |
|------------------------------------|-----------------------------------|
| А. Зуны өглөөний тааламжтай байдал | В. Малчин хүний жаргалтай амьдрал |
| С. Адуучин эрийн жавхаатай байдал | Д. Хөхөө шувууны яруухан дуу |
| Е. Хөдөө талын ариун агаар | |
3. Эх хэдэн цогцолбороос бүтсэн байна вэ?
- А. “Үүрийн цагаан гэгээ ... үнэхээр тааламжтай”, “Хөх тэнгэр тунгалагаар цэлмээд ... залгалдана”, “Урьхан салхи ... нийтлэн шарлав”, “Үүнд Цогт хүү ... хөдлөн хурав” гэсэн 4 цогцолбор
- В. “Үүрийн цагаан гэгээ ... залгалдана”, “Урьхан салхи ... нийтлэн шарлав”, “Үүнд Цогт хүү .. хөдлөн хурав” гэсэн 3 цогцолбор
- С. “Үүрийн цагаан гэгээ ... нийтлэн шарлав”, “Үүнд Цогт хүү ... хөдлөн хурав” гэсэн 2 цогцолбор
- Д. “Үүрийн цагаан гэгээ ... хөдлөн хурав” гэсэн 1 цогцолбор
- Е. “Үүрийн цагаан гэгээ ... залгалдана”, “Урьхан салхи ... хөдлөн хурав” гэсэн 2 цогцолбор

4. Дээрх эх найруулгын ямар төрөлд хамаарах вэ?
 А. Албан бичгийн В. Ярианы С. Уран зохиолын
 D. Сонин нийтлэлийн E. Эрдэм шинжилгээний
5. Эхийн хэв маягийг тодорхойл
 А. Юмсын шинжийг зураглан тоочсон тоочимж
 В. Ойлголт ухагдахууныг үгүйсгэж баталсан эргэцүүлэмж
 С. Хэрэг явдлын учир шалтгааныг тайлбарласан тайлбарламж
 D. Хэрэг явдлыг цагийн дарааллаар цувуулан өгүүлсэн хүүрнэмж
 E. Хэрэг явдлын мөн чанарыг учирлан өгүүлсэн учирламж
6. Дээрх эхийн "... хөвөн үүл хэсэг хэсгээр тунана" гэсэн хэсгийн дүрслэх ур маягийн учир юу вэ?
 А. Тарж сарнисан нимгэн үүл байсан учир хөвөнтэй адилтгасан
 В. Нэлэнхүйд нь бүрхсэн бөөн үүл байсан учир хөвөнтэй адилтгасан
 С. Бөөн бөөн зузаан хар үүл байсан учир хөвөнтэй адилтгасан
 D. Суунагласан бүдэг цагаан үүл байсан учир хөвөнтэй адилтгасан
 E. Бөөн бөөн тунгалаг цагаан үүл байсан учир хөвөнтэй адилтгасан
7. Дараах тодорхойлолтын цэгийн оронд тохирох үгийг олоорой.
 "Тол сэдэвтэй, тухайн нэг хэрэг явдлыг өгүүлсэн хэд хэдэн үйл явдал бүхий төгс санаат бүтцийг гэнэ."
 А. Үг В. Холбоо үг С. Өгүүлбэр
 D. Нийлмэл өгүүлбэр E. Цогцолбор
8. Дээрх эхийн "...энэ үе сайхан зуны тэргүүн сарын шинэд тул дэлхийн бодис ба цагийн улирал үнэхээр тааламжтай" гэдэгт хэний үнэлэмж илэрч байна вэ?
 А. Цогт хүүгийн үнэлэмж илэрсэн
 В. Зохиогчийн үнэлэмж илэрсэн
 С. Уншигчийн үнэлэмж илэрсэн
 D. Залуу хүүгийн үнэлэмж илэрсэн
 E. Уншигч, Цогт хүү хоёрын үнэлэмж илэрсэн
9. Дараах өгүүлбэрийн онцлон тодруулсан хэсгийн бүтцийг тодорхойл.
 Үүрийн цагаан гэгээ тусмагц хөхөө шувуу урьханаар донгодох дуу уулын цуурай ба салхины аятай хослон өргөн талд дэлгэрэнгүйеэ хангинав.
 А. Хамжсан тодотгол гишүүн өгүүлбэр В. Үйлийн тодотгол гишүүн өгүүлбэр
 С. Харьяалахын тодотгол гишүүн өгүүлбэр D. Дүрийн байц гишүүн өгүүлбэр
 E. Цагийн байц гишүүн өгүүлбэр
10. Дээрх (9-р) өгүүлбэрийн хоёр бүрэлдэхүүнт цөм бүтцийг зөв тодорхойлсныг ол.
 А. Талд хангина В. Хослон хангина
 С. Урьханаар хангина D. Дуу хангина
 E. Дэлгэрэнгүйеэ хангина
11. Дээрх эхэд цаг хугацааны харьцааг хэрхэн илэрхийлсэн байна вэ?
 А. Шөнө дунд - үүрийн гэгээ В. Өглөөний нар - үдийн халуун
 С. Үүрийн гэгээ - өглөөний нар D. Үдшийн бүрий - үүрийн гэгээ
 E. Өглөөний нар - үд дунд
12. Дараах холбоо үгсээс аль нь бүхэлзүйжсэн холбоо үг вэ?
 А. Донгодох дуу В. Хөх тэнгэр С. Цагаан гэгээ
 D. Хөхөө шувуу E. Ногооны униар
13. Дараах өгүүлбэрийн "урьхан" гэсэн үгийг утгаар нь солин найруулбал аль үг хамгийн оновчтой байж болох вэ?
Урьхан салхи зөөлнөөр найгаад, ариун агаар цээж дүүрэн амьсгалуулна.
 А. Халуун В. Хавсарга С. Жихүүн
 D. Улаан E. Намуун
14. Дараах өгүүлбэрийг салаалан хувиргасныг олоорой.
Дэргэдэх ургамал, цэцгэнд нимгэн цагаан хяруу гилтгэнээд, тэртээ ой модонд ногооны униар залгалдана.
 А. Хажуугийн өвс, жимсэнд үл мэдэг хяруу унасан нь гялтганаад, алсын өндөр уулсад будан хүдэн суунаглана.
 В. Тэртээ ой модонд ногооны униар залгалдаад, дэргэдэх ургамал, цэцгэнд нимгэн цагаан хяруу гилтгэнэнэ.
 С. Цагаан хяруу гилтгэнээд, ногооны униар залгалдана.
 D. Дөрөө шүргэм сагсайтал ургасан ургамал, цэцгэнд өглөөний нимгэн цагаан хяруу үзэсгэлэнтэйеэ гилтгэнээд, алсад цэнхэртэх тэртээ холын ой модонд хөх ногооны униар залгалдана.
 E. Дэргэдэх ургамал, цэцгэнд нимгэн цагаан хяруу гилтгэнээд, тэртээ ой модонд ногооны униар залгалдах нь ертөнцөд нэгэн шинэ өглөө айлчилж байгааг зарлана.

15. Дараах өгүүлбэрээс захын дэлгэрүүлэгч буюу орны байц гишүүнийг ол.
Удалгүй дүгрэг том нар мандан гарч ирэхэд баруун ба хойд уулын орой ба энгэрээр гэрэл тусаад, өмнөх их талд туяа нийтлэн шарлав.
- А. Удалгүй В. Энгэрээр С. Баруун
D. Нар E. Дүгрэг
16. Үгийн бүтцээр зөв задалсныг олоорой.
- А. Баяр - с - галан - тай В. Баян - с - га - лан - тай С. Баяр - с - га - лан - тай
D. Баяс - гал - ан - тай E. Баяр - сга - лан - тай
17. Дараах өгүүлбэрээс үйл явдлыг зэрэгцүүлэн холбох үүрэгтэй бүтээврийг олоорой.
Хөх тэнгэр тунгалагаар цэлмээд, хөвөн үүл хэсэг хэсгээр тунана.
- А. -аар В. -ээр С. -ээд D. -на E. -р
18. Эхээс түвэрлэсэн үгсийн зүйлчлэлийг ажиглаад утгын хамааралгүй үгийг ол шилгээх, хөрвөөх, шарвах, хэвтэх, янцгаах, годгонох
- А. Хөрвөөх В. Годгонох С. Шилгээх
D. Янцгаах E. Шарвах
19. Бүгд үйлийн хам холбох “-н” нөхцөлтэй үг орсон хэсгийг олоорой.
- А. Цагаан, урьхан, яруухан В. Арчин, сайхан, агшин
С. Тэргүүн, дөрвөн, дэлхийн D. Нимгэн, мандан, нийтлэн
E. Мордон, эвшээн, эргэлдэн
20. Дараах өгүүлбэрт нэрийн тийн ялгалын нөхцөлтэй үг хэд байна вэ?
Удалгүй дүгрэг том нар мандан гарч ирэхэд баруун ба хойд уулын орой ба энгэрээр гэрэл тусаад, өмнөх их талд туяа нийтлэн шарлав.
- А. 5 В. 6 С. 7 D. 8 E. 9
21. “Агшин” гэдэг үгийн ойролцоо утгат үг аль нь вэ?
- А. Мөч В. Хором С. Мөд D. Сая E. Алдаг оног
22. Дараах холбоо үгсийн бүгдэд нь тохирох шинжийг олоорой.
“Үүрийн гэгээ, зуны сар, дэлхийн бодис, цагийн улирал, ногооны униар”
- А. Хамжиж угсарсан нэрийн холбоо үг В. Найрч угсарсан нэрийн холбоо үг
С. Дагуул үг нь бүгд цагийн нэр D. Цөм үг нь бүгд орон заасан үг
E. Бүгд зэрэгцэн холбогдсон
23. Өнгө заасан тэмдэг нэр шилжсэн утгаар орсон өгүүлбэрийг олж тэмдэглээрэй.
- А. Нимгэн цагаан хяруу гилтгэнэнэ. В. Үүрийн цагаан гэгээ тусна.
С. Харц бүдрэх чулуугүй, Дуутын цагаан хөтөл. D. Цав цагаан, энгэсэг оо шиг цас.
E. Нарны цагаан тоос сэрвээн дээр бударна.
24. Төрөл үгийг буруу бүтээсэн хэсгийг олоорой.
- А. Суудал, сууц В. Суултуур, суумал С. Суурин, суугч
D. Суурь, суусар E. Суутгал, суурьшил
25. Дараах харилцан ярианд “ок” гэдэг харь үг хэрэглэсэн нь зөв үү? Зөв хариултыг олоорой.
“- Найз аа, би чиний захисныг авчирсан.
- Ок, баярлалаа”
- А. Харь үг нь тухайн улсын нийгэмд гарсан томоохон өөрчлөлтийг дагаж нэвтэрдэг учраас зөв
В. Хүмүүсийн хооронд илүү дотно харилцааг үүсгэдэг үг
С. Ийм үг, яриаг илүү чимж өгдөг учраас зөв
D. Харь үгийг хэрэглэхгүй байх нь боловсролгүйн шинж
E. Төрөлх хэлний цэвэр байдлыг эвддэг этгээд үгийн нэг хэлбэр
26. Үгийн аймгаар зөв бүлэглэсэн хэсгийг олоорой.
- А. Гэгээ, хөхөө, дуу, урьхан, шувуу, тал
В. Цагаан, өргөн, яруу, нимгэн, ариун, их
С. Дээр, дотор, цаана, дүүрэн, урдуур, гадагш
D. Тусах, донгодох, хангинах, тэртээх, цэлмэх
E. Дөрвөлжин, дээшээ, дээвэр, дэлхий, давхи
27. “Татах” гэдэг үгийн салаа утгат үгсээс доорх тайлбарт тохирох хэсгийг олоорой.
Үгийн тайлбар нь: хурааж авах, хумих, эмхлэх, ойртуулах
- А. Хэл татах В. Хань татах С. Өвс татах
D. Тамхи татах E. Манан татах
28. Дээрх эхэд байгаа “ариун агаар” хэмээх холбоо үгийн утга, бүтцийг ажиглаад адил үүрэгтэй үгийг олоорой.
- А. Тунгалаг мөрөн В. Шаргал тэмээ С. Түмэн агт
D. Энх улирал E. Дээд тэнгэр

29. Монгол хэлний цагаан толгой хэдэн гийгүүлэгч үсэгтэй вэ? .
 А. 13 В. 9 С. 7 D. 35 E. 20
30. 5 үсэг, 4 авианаас бүтсэн үгийг олоорой.
 А. Хүлэг В. Хаана С. Хурга D. Цэрэг E. Номин
31. Дараах өгүүлбэрт байгаа хашилтыг хасвал өгүүлбэрт утга санааны өөрчлөлт гарах уу? Зөв хариултыг олоорой.
 “Ирэхгүй” ээжээ зүүдэлж байхад чинь сэрээчихсэн бол, их нүгэлтэй намайгаа уучлаарай. (Б.Лхагвасүрэн)
 А. Утга санаа нь огт өөрчлөгдөхгүй
 В. Өгүүлбэрийн гишүүдийн байр хувирахгүй учраас төдий л өөрчлөгдөхгүй
 С. Тухайн үг шууд утгатай болох учир өөрчлөгдөнө
 D. Өгүүлбэрийн бүх гишүүд нь хэвээр байгаа учраас өөрчлөгдөхгүй
 E. Зөвхөн өгүүлбэрийн бүтэц өөрчлөгдөнө
32. Өгөх оршихын тийн ялгалын “-д” нөхцөл залгахад аль үг нь бусдаасаа өвөрмөц бичигдэх вэ?
 А. Сургууль В. Боть С. Хань D. Хавь E. Шавь
33. Бүгдийг зөв бичсэн хэсгийг олоорой.
 А. Арлаас, бодлоос, гэрэлээс В. Атраас, болороос, өдрөөс
 С. Хөгчөөс, аймгаас, домгоос D. Бөмбөрцгөөс, бүлгээс, чихэрээс
 E. Ястанаас, төрөлхтнөөс, үсчинээс
34. Дараах өгүүлбэрийг крилл бичигт зөв хөрвүүлснийг олоорой.

 А. Олны доор үгээ бэхэл
 Ганцаар суухад сэтгэлээ шинжил
 В. Улан доор үгээ бэхэл
 Ганцаар суухад сэтгэлээ шинжил
 С. Олны дотор үгээ бэхэл
 Ганцаар суухад сэтгэлээ шинжил
 D. Олны дотор үгээ бэхэл
 Ганцаар суухад сэтгэлээ шинэчил
 E. Олны дотор үгээ бэхэл
 Ганцаар санахад сэтгэлээ шинэчил
35. Монгол бичигт тэмдэг нэр бүтээх “ᠠᠨᠢ” дагавар авах үг аль нь вэ?
 А. Тур В. Эц С. Түл D. Хөр E. Туш
36. Нэрийн тийн ялгалын нөхцөлөөр буруу хувилгасныг олоорой.
 А. ᠠᠨᠢ ᠨᠢᠨ В. ᠠᠨᠢ ᠨᠢᠨ C. ᠠᠨᠢ ᠨᠢᠨ D. ᠠᠨᠢ ᠨᠢᠨ E. ᠠᠨᠢ ᠨᠢᠨ
37. Монгол бичгээр урт эгшгийг “Э - Г - Э” гэсэн нийлэмжээр тэмдэглэдэг үгийг олоорой.
 А. Жишээ В. Хууль С. Хүүхэд D. Баатар E. Туулай
38. “Монголын Нууц Товчоон” зохиолд:
 “... Хөрст дэлхий хөрвөж, хөвчин улс хямралдаж
 Хөнжилдөө унтах завгүй, хөнөөлдөн тэмцэж байв...” хэмээн шүлэглэсэн нь хэдий үеийн монголчуудын нийгмийн байдлыг дүрсэлсэн бэ?
 А. Хүннүгийн үе В. XIII зууны үе C. Сянбигийн үе
 D. XV зууны үе E. XI зууны үе
39. Доорх зохиолуудын дарааллыг ажиглаад, зөв зүй тогтлыг олоорой.
 А. “Монголын Нууц Товчоон”, “Оюун түлхүүр”, Д.Нацагдорж “Од”, Д.Нямаа “Шөнийн талд адуу янцгаана”
 В. “Монголын Нууц Товчоон”, “Чингисийн билиг”, Д.Нацагдорж “Од”, Д.Нямаа “Шөнийн талд адуу янцгаана”
 С. Д.Равжаа “Үлэмжийн чанар”, “Оюун түлхүүр”, Д.Нацагдорж “Од”, Д.Нямаа “Шөнийн талд адуу янцгаана”
 D. Д.Равжаа “Үлэмжийн чанар”, Б.Явуухулан “Говь”, Д.Нацагдорж “Од”, Д.Нямаа “Шөнийн талд адуу янцгаана”
 E. Б.Явуухулан “Говь”, Д.Нацагдорж “Од”, Д.Нямаа “Шөнийн талд адуу янцгаана”, Б.Лхагвасүрэн “Буруу энгэртэй дээл”
40. С.Эрдэнийн өгүүллэгүүдийн гол онцлог нь юу вэ?
 А. Байгалийн уран дүрслэл В. Нийгэм, цаг үеийн тухай уран дүрслэл
 С. Элбэрэл хайрын уран дүрслэл D. Дүрийн сэтгэлзүйн уран дүрслэл
 E. Хөдөө аж ахуйн тухай уран дүрслэл

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Өгүүлбэрийн цэгийн оронд тохирох үгийг нөхөж морины явдлыг удаанаас түргэн рүү ахиулан дүрсэлсэн цогцолбор бүтээгээрэй. (5 оноо)
- | | |
|-------------------------------|----------------|
| А. Аранзал зээрд мориороо ... | 1. Давхиуллаа |
| В. Тэгснээ ... | 2. Алхууллаа |
| С. Тэгээд ... | 3. Шогшууллаа |
| Д. Дараа нь ... | 4. Цогиуллаа |
| Е. Сүүлд нь ... | 5. Хатирууллаа |
- 2.2. Хэлц өгүүлбэрийг гол санаатай нь зөв харгалзуулаарай. (5 оноо)
- | | |
|--|---------------------|
| А. Бяруу болоогүй байж бух болох | 1. Цэглэх болоогүй |
| В. Бушуу туулай борвиндоо баастай | 2. Бүтэшгүй үйл |
| С. Могой гурав тасравч гүрвэлийн чинээ | 3. Хэрээсээ хэтрэх |
| Д. Нар баруун хойноос гарах | 4. Найдваргүй болох |
| Е. Эмээлээ гэдсэндээ авах | 5. Түргэн түүхий |
- 2.3. Дараах холбоо үг, өгүүлбэрийн найруулгын алдааг тодорхойлж зөв харгалзуулаарай. (5 оноо)
- | | |
|--|----------------------------|
| А. Тавь гаруй иргэд | 1. Үг буруу сонгосон |
| В. Намар оройн бороонд гөлөглөсөн навч | 2. Үг илүүдсэн |
| С. Илүү нэмэгдэх, хамтарч ярилцах | 3. Тооны дагавар илүүдсэн |
| Д. Торомгор хар нүдийг нь саравчилсан хөмсөг | 4. Учир зүйг зөрчсөн |
| Е. Нохойн хошуу гоо сайханд ашигтай | 5. Яруу хэрэглүүр оновчгүй |
- 2.4. Монгол нутгийн тухай шүлгүүдэд юуг онцлон дүрсэлснийг зөв харгалзуулаарай. (5 оноо)
- | | |
|--------------------------------------|------------------------------------|
| А. Б.Явуухулан “Би хаана төрөө вэ?” | 1. Байгалийн эд баялгийн талаас нь |
| В. Д.Нацагдорж “Миний нутаг” | 2. Газарзүйн байрлалын талаас нь |
| С. Ц.Дамдинсүрэн “Монгол нутаг” | 3. Иргэн хүнийх нь талаас |
| Д. Б.Лхагвасүрэн “Боржигоны бор тал” | 4. Эрхэлдэг аж ахуйн талаас нь |
| Е. П.Бадарч “Есөн эрдэнийн орон” | 5. Эгэл гайхамшиг талаас нь |

2008 оны Монгол хэлний хичээлийн даалгаврын түлхүүр

Нэгдүгээр хэсэг					
Хувилбарууд					
№	A	C	D	E	G
1	B	C	D	B	B
2	C	B	C	D	A
3	D	B	A	A	C
4	A	B	D	E	C
5	D	A	B	E	D
6	E	C	C	C	E
7	A	A	B	D	E
8	A	E	C	C	B
9	B	E	C	B	A
10	B	D	D	A	D
11	C	D	E	B	C
12	E	A	A	E	D
13	D	D	D	B	E
14	E	C	D	C	A
15	D	D	B	C	B
16	C	C	C	A	C
17	B	B	E	D	C
18	A	B	B	C	D
19	E	D	C	A	E
20	A	C	A	B	D
21	C	E	D	E	B
22	B	A	E	B	B
23	D	D	D	C	E
24	B	C	B	D	D
25	D	B	E	B	E
26	C	D	D	C	B
27	E	C	B	E	C
28	D	D	A	C	D
29	C	C	E	D	E
30	A	A	B	E	B
31	E	C	D	B	C
32	A	B	C	A	B
33	B	C	A	B	C
34	D	E	D	B	C
35	C	E	E	C	A
36	E	A	B	E	C
37	A	D	C	E	D
38	C	B	B	E	B
39	D	E	E	C	E
40	C	B	A	B	D

Хоёрдугаар хэсэг																				
№	А хувилбар				С хувилбар				D хувилбар				Е хувилбар				G хувилбар			
	2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4	2.1	2.2	2.3	2.4
a	2	2	3	1	4	5	4	5	3	4	5	3	5	4	4	3	2	3	3	3
b	4	3	4	5	1	1	2	1	5	1	4	1	3	5	5	1	3	5	4	2
c	5	1	5	2	5	2	5	2	4	5	2	4	1	1	2	2	5	1	2	4
d	1	5	2	4	3	3	1	3	2	2	1	5	2	3	1	5	4	2	5	5
e	3	4	1	3	2	4	3	4	1	3	3	2	4	2	3	4	1	4	1	1